



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ

Хүн худалдаалах гэмт хэргээс хүүхдийг хамгаалах нь
төслийн тайлан 2020-2026

CHILD PROTECTION COMPACT:

Protecting Children from Human Trafficking – Project Report 2020–2026



*Мэдэгдэл
Disclaimer*

This report was funded by a grant from the United States Department of State. The opinions, findings and conclusions stated herein are those of the author and do not necessarily reflect those of the United States Department of State.

Энэхүү тайланг АНУ-ын Төрийн департаментын буцалтгүй тусламжаар хэвлүүлэв. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ:

Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь
ТӨСӨЛ

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдийн бие махбодийн болон сэтгэл санааны гэмтэл хохирлыг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээ, тусламж үзүүлэх, гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг бэхжүүлж хүүхдэд ээлтэй байдлаар зохион байгуулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, эдгээр үйл ажиллагаан дахь төрийн болон төрийн бус байгууллага, салбар дундын уялдаа холбоог хангах, сайжруулах зорилгоор АНУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээг 2020 оны 4-р сарын 2-нд байгуулсан.

Энэхүү түншлэлийн хүрээнд, АНУ-ын Төрийн Департаментийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх газрын санхүүжилтээр Дэлхийн Зөн олон улсын байгууллага (ДЗОУБ), Азийн Сан болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийг 2020 оны 10-р сараас хэрэгжүүлжүүлж байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН КОМПАКТ ТҮНШЛЭЛ CHILD PROTECTION COMPACT PARTNERSHIP



Төслийн үндсэн зорилт

Зорилт1. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах

Зорилт2. ХХГХ-ийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх

Зорилт3. ХХГХ-ийн хохирогч хүүхдийг таньж илрүүлэх, тэдэнд цогц үйлчилгээг үзүүлэх төрийн болон иргэний нийгмийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх

Зорилт4. ХХГХ-т өртсөн хүүхдийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх

CHILD PROTECTION COMPACT: Protecting Children from Trafficking PROJECT

In order to provide comprehensive services and assistance aimed at rehabilitating the physical and psychological harm suffered by children who have been victims of human trafficking in Mongolia; to strengthen a victim-centered and child-friendly approach in criminal justice procedures; to prevent this type of crime; to increase public awareness and understanding; and to ensure and improve coordination and cooperation among government and non-governmental organizations and across sectors, the Child Protection Compact Agreement was signed between the Government of the United States of America and the Government of Mongolia on April 2, 2020.

Within the framework of this partnership, the Child Protection Compact: Protecting Children from Trafficking Project has been implemented since October 2020 through funding from the U.S. Department of State, Office to Monitor and Combat Trafficking in Persons, in cooperation with World Vision International, The Asia Foundation, and other governmental and non-governmental organizations.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН КОМПАКТ ТҮНШЛЭЛ CHILD PROTECTION COMPACT PARTNERSHIP



Project Objectives

Objective 1: To strengthen intersectoral coordination and collaboration in efforts to combat and prevent human trafficking.

Objective 2: To improve investigation and prosecution of human trafficking crimes and to enhance the capacity of relevant officials.

Objective 3: To strengthen the capacity of government and civil society organizations to identify child victims of human trafficking and provide them with comprehensive services.

Objective 4: To increase public awareness and understanding of child victims of human trafficking and to strengthen the capacity of government, private sector, and civil society organizations to prevent human trafficking.

АГУУЛГА-CONTENTS

- 06** ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ
CHILD PROTECTION SYSTEM MAPPING
- 08** ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ
SUPPORTING THE REFORM OF THE CHILD PROTECTION LEGAL FRAMEWORK
- 10** ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ
IMPROVING THE LEGAL FRAMEWORK TO COMBAT TRAFFICKING IN PERSONS
- 12** ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ
INTRODUCING NEWLY ADOPTED AND REVISED PROCEDURES
- 14** САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
SUPPORT TO THE MULTI-DISCIPLINARY TASK FORCE
- 16** САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
CAPACITY BUILDING FOR THE MULTI-DISCIPLINARY TASK FORCE
- 18** ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ
STUDY TOURS
- 20** ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ӨРӨӨ
CHILD-FRIENDLY SPACE
- 24** ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ТАСГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
STRENGTHENING THE CAPACITY OF THE ANTI-TRAFFICKING UNIT
- 26** ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН
ANNUAL DATA-DRIVEN REPORTS
- 28** ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА:
АСУУДАЛ, ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ANNUAL PROSECUTION WORKSHOPS
- 30** ХАМГААЛАХ БАЙРНЫ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
STRENGTHENING THE CAPACITY OF SHELTERS
- 32** ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАДАВХЖУУЛАХ
CAPACITY BUILDING OF CHILD PROTECTION SERVICE
- 34** ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА СУРГАЛТ
TRAINING ON INVESTIGATING AND PROSECUTING TRAFFICKING IN PERSONS CASES WITH
VICTIM-CENTERED AND CHILD-FRIENDLY APPROACHES
- 36** КИБЕР ОРЧИНД ҮЙЛДЭГДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ СУРГАЛТ
TRAINING ON ADJUDICATION OF CYBER-FACILITATED TRAFFICKING IN PERSONS CASES
- 38** ФОРЕНЗИК ЯРИЛЦЛАГА
FORENSIC INTERVIEW
- 40** МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ АРГА БАРИЛ, ХАНДЛАГА, ХҮН
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ДАВАН ТУУЛАГЧ ХҮҮХЭДТЭЙ СЭТГЭЦИЙН
ГЭМТЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛААР АЖИЛЛАХ НЬ СУРГАЛТ
TRAINING ON A VICTIM-CENTERED APPROACH TO CRIMINAL INVESTIGATIONS / TRAUMA-
INFORMED APPROACHES FOR INTERVIEWING CHILD VICTIMS OF TRAFFICKING IN PERSONS
- 42** КИБЕР ОРЧНЫГ АШИГЛАЖ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ
АЖИЛЛАГАА СУРГАЛТ
TRAINING ON INVESTIGATING CYBER-FACILITATED TRAFFICKING IN PERSONS CASES
- 43** ХИЛ ДЭЭРХ СУРГАЛТ
TRAINING AT BORDER CHECKPOINTS

- 44** ХОХИРОГЧИЙГ ТАНЬЖ ИЛРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ
CAPACITY BUILDING OF FRONTLINE WORKERS ON IDENTIFICATION OR VICTIMS OF TRAFFICKING
- 46** ХИЛ ДЭЭРХ ДАМЖИН ӨНГӨРӨХ АЖИГЛАЛТ
BORDER MONITORING
- 48** ВИДЕО ХИЧЭЭЛҮҮД
VIDEO TRAINING COURSES
- 49** ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛӨЛТИЙН ТАЛААР СУДАЛГААНУУД
STUDIES ON COMPENSATION FOR VICTIMS OF CRIME
- 50** ДАТА МЭДЭЭЛЛИЙН САНГ САЙЖРУУЛАХ
IMPROVING DATABASE
- 51** ДАВАН ТУУЛАГЧДЫН СҮЛЖЭЭ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ
ESTABLISHING A SURVIVORS' NETWORK
- 52** ХОХИРОГЧИД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ САЙН ДУРЫН АЖИЛТАН БЭЛТГЭХ
PREPARATION OF VICTIM ADVOCATES
- 54** ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
ДҮН ШИНЖИЛГЭЭ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА
COMPARATIVE ANALYSIS OF THE ADJUDICATION OF TRAFFICKING IN PERSONS AND SEXUAL
EXPLOITATION CRIMES
- 56** АЛБАДАН ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН МӨЛЖЛӨГИЙН ЗОРИЛГООР
ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН
RESEARCH REPORT ON THE ADJUDICATION OF TRAFFICKING IN PERSONS FOR THE PURPOSE OF
FORCED LABOR AND LABOR EXPLOITATION
- 58** ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
ANALYSIS ON LEGAL PROCEEDINGS OF TRAFFICKING IN PERSONS AND SIMILAR CASES
- 60** ХОХИРОГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН САН
CHILD VICTIM REGISTRATION SYSTEM
- 61** ГЭРЭЭР АЙЛЧЛАГЧ ХӨТӨЛБӨР
HOME VISITOR PROGRAM
- 62** ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ХҮҮХДЭД
ЭЭЛТЭЙ, СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ НЭВТРҮҮЛЭХ
INTEGRATING VICTIM-CENTERED, CHILD-FRIENDLY, AND TRAUMA-INFORMED APPROACHES INTO
THE ACADEMIC CURRICULUM OF THE UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS
- 64** ХҮҮХДИЙН ЭРХИЙН БАЙЦААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ
CAPACITY BUILDING FOR STATE CHILD RIGHTS INSPECTORS
- 66** АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ
PROMOTING CHILD RIGHTS IN BUSINESS ACTIVITIES
- 68** ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨН
NATIONAL FORUMS ON CHILD LABOR
- 70** ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ
CHILD AND YOUTH EMPOWERMENT
- 74** ХАКАТОН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
HACKATHON COMPETITION
- 76** УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЯН
PREVENTION CAMPAIGNS

ТӨСЛИЙН ЗОРИЛТ

Project Objectives



Хамтын ажиллагаа - Partnership



Хэрэг хянан шийдвэрлэх - Prosecution



Хүүхэд хамгаалал - Protection



Урьдчилан сэргийлэх - Prevention

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ

2021 онд “Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал” судалгааг Дэлхийн Зөн олон улсын байгууллагын ADAPT (Analysis, Design and Planning Tool) аргачлалаар гүйцэтгэж, хууль эрх зүй, үйлчилгээний бүтэц ба механизм, чадавх ба нөөц, хариуцлага ба засаглал, салбар дундын уялдаа холбоо, хүүхдийн оролцоо зэрэг тогтолцооны гол бүрэлдэхүүнүүдийг иж бүрэн үнэлэн гаргав.


Судалгааны арга зүй, төслийг олон талуудаар хэлэлцүүлэн, мэдээллийг цуглуулахдаа холбогдох яам, агентлаг, Улаанбаатарын гурван дүүрэг болон дөрвөн аймгийн хүүхэд хамгааллын хэлтэс нэгжүүд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн, Салбар дундын хамтарсан багийн гишүүд, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, нийт 30 гаруй байгууллагын төлөөлөлтэй хагас бүтэцчиглэгдсэн, 23 байгууллагын мэргэжилтэн албан хаагчтай ганцаарчилсан, 128 хүүхэд, эцэг эх, үйлчилгээ үзүүлэгчтэй ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэн мэдээлэл санал авч үр дүнг нэгтгэн дүгнэсэн. Үр дүнг олон талт олон удаагийн хэлэлцүүлэгт оруулснаар



хүүхэд хамгааллын бодлого, үйлчилгээний хэрэгжилтийн сул тал, салбар хоорондын уялдаа холбооны доголдлыг үндэсний түвшинд нэгдсэн ойлголт болгож чадсан.



ADAPT ийн үнэлгээ нь хүүхэд хамгааллын тогтолцоонд суурь түвшний томоохон бодлогын үр дүн, давуу тал, хоосон орон зайг нотолгоотойгоор тодорхой харуулж чадсан тул Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан батлуулах үед чухал баримт бичгийн нэг болж эрх зүйн холбогдох шинэчлэлийг бодит мэдээлэл, олон талын оролцоо, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн гаргахад түлхэц өгсөн.



CHILD PROTECTION SYSTEM MAPPING

In 2021, the study “Mapping of the Child Protection System in Mongolia” was conducted using World Vision International’s ADAPT (Analysis, Design and Planning Tool) methodology. Through this approach, the assessment comprehensively examined the key components of the national child protection system, including the legal and policy framework, service structure and mechanisms, human and financial resources, accountability and governance, cross sectoral coordination, and child participation.

The study applied a participatory and multi stakeholder methodology. Data collection involved consultations with relevant ministries and government agencies, child protection units of three districts of Ulaanbaatar and four aimags, members from Coordinating Council for Crime Prevention, and multi-disciplinary task force, and representatives of civil society and international organizations. In total, the research engaged over 30 institutions through semi structured interviews, conducted individual interviews with staff from 23 organizations, and held group discussions with 128 children, parents, and service providers. By synthesizing the data and presenting the findings through multiple rounds of stakeholder consultations, the study helped establish a shared national understanding of the key gaps in policy implementation, service delivery, and cross sectoral cooperation within the child protection system.

The ADAPT assessment identified, with clear evidence, the major systemic strengths, gaps, and policy implications at the foundational level of child protection in Mongolia. As a result, the study served as an important reference document during the drafting and approval of the revised Child Protection Law, contributing to the development of evidence based and participatory legal reforms aligned with emerging needs and international best practices.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ

2024 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарснаар холбогдох дүрэм, журмыг боловсруулан гаргах, батлуулах ажилд төслийн зүгээс ГБХНХЯ-д дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Үүний үр дүнд дараах баримт бичгүүд батлагдсан хэрэгжиж эхлэв. Үүнд:



Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 142 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.



Хүүхдийн эрхийн байцаагчийн орон тоог тогтоох аргачлал Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 143 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.



Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам 2025 оны 3 сарын 28-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан А/53, А/95, А/76 тоот тушаалаар батлагдсан.



Хэвлэл мэдээлэл, цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар батлагдав.








Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байранд тавих нийтлэг шаардлага MNS 7090:2025 стандарт 2025 оны 12-р сард батлагдав.

Эдгээр эрх зүйн баримт бичгүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг таньж тогтоох, холбон зуучлах, хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үндэсний хууль тогтоомжийн нэгэн чухал бүрдэл хэсгүүд болж байна.






ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

Төслийн зүгээс 2023 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Хуульд заасан зарим журмуудыг батлаагүй, зарим баталсан журмуудын заалт нь зөрчилдөж байгаа зэргээс шалтгаалан хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг үнэлгээний тайланд дүгнэсэн. Үүний дагуу төслийн зүгээс Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-тай хамтран хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах, журам, стандартыг батлуулах ажилд холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажилласан.

-  ХХГХ-ийн хохирогчид эрүүл мэндийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам – Эрүүл мэндийн сайдын А/64 дугаар тушаал – 2026.02.26
-  ХХГХ-ийн хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам - Эрүүл мэндийн сайдын А/64 дугаар тушаал – 2026.02.26
-  Салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журам - Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/156 дугаар тушаал - 2025.12.16
-  Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам - Монгол Улсын засгийн газрын 215 дугаар тогтоол - 2024.12.18
-  Хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам (шинэчилсэн) - Гадаад харилцааны сайдын А/71 дүгээр тушаал - 2024.11.12
-  Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам (шинэчилсэн) - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/40 дүгээр тушаал - 2024.10.18
-  Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам - Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан А/60, А40 дүгээр тушаал - 2024.03.04
-  Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам - Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/399 дүгээр тушаал - 2023.11.20

Дээрх эрх зүйн зохицуулалтын шинэчлэл нь хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлчилгээг илүү уялдаатай үзүүлэх тогтолцоог бий болгоход чухал алхам болсон.











IMPROVING THE LEGAL FRAMEWORK TO COMBAT TRAFFICKING IN PERSONS

In 2023, the project conducted an impact assessment of the implementation of the Law on Combating Trafficking in Persons. The assessment found that the implementation of the law had been limited due to several factors, including the absence of some required procedures and inconsistencies among certain approved procedures.

Based on the findings, the project worked in partnership with the Gender Equality Center NGO to support relevant government institutions in strengthening the legal framework for combating trafficking in persons and in developing and approving necessary procedures and standards.

With this support, several key procedures were approved:

-  Procedure on providing health rehabilitation services to victims of trafficking in persons – Order A/64 of the Minister of Health (February 26, 2026)
-  Procedure on providing mental health services to victims of trafficking in persons – Order A/64 of the Minister of Health (February 26, 2026)
-  Standard Operating Procedures of the MDTF – Order A/156 of the Minister of Justice and Home Affairs (December 16, 2025)
-  Procedure on the structure, organization, and operation of shelters – Resolution No. 215 of the Government of Mongolia (December 18, 2024)
-  Procedure on providing services for victims of TIP (revised) – Order A/71 of the Minister of Foreign Affairs (November 12, 2024)
-  Procedure on providing victims with jobs and enrolling them in vocational training for (revised) – Order A/40 of the Minister of Family, Labor and Social Protection (October 18, 2024)
-  Procedure on ensuring human dignity and safety of TIP victims – Joint Orders A/60 and A/40 of the Minister of Justice and Home Affairs and the Prosecutor General (March 4, 2024)
-  Procedure on legal assistance for victims of TIP – Order A/399 of the Minister of Justice and Home Affairs (November 20, 2023)

These legal and regulatory improvements represent an important step toward strengthening victim protection, enhancing prevention efforts, and establishing a more coordinated system of services for victims of trafficking in persons.



ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ЖУРМУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ

Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр болон шинэчлэн батлагдсан журмуудыг салбарын мэргэжилтнүүдэд танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аар дамжуулан зохион байгууллаа. 2024 оны 4 сараас эхлэн 10 уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хууль сахиулах, нийгмийн хамгаалал, гадаадын иргэн, харьяат, эрүүл мэндийн зэрэг салбарын нийт 613 (423 эм; 190 эр) мэргэжилтнийг хамруулсан. Уулзалт хэлэлцүүлгүүдийн үеэр шинээр болон шинэчлэн батлагдсан журмуудыг танилцуулахаас гадна салбарын мэргэжилтнүүд тухайн журмуудыг хэрхэн ажил дээрээ хэрэгжүүлэх талаар санал солилцон, тулгарч буй бусад асуудлуудынхаа талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.



190 эрэгтэй



423 эмэгтэй

Эдгээр уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд батлагдсан журмууд практик дээр нэг мөр хэрэгжих боломжтой болж, холбогдох байгууллагууд ХХГХ-ийн хохирогчид илүү тодорхой, цогц, уялдаатай үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.





INTRODUCING NEWLY ADOPTED AND REVISED PROCEDURES

As part of the legal reforms to combat trafficking in persons, the project organized a series of meetings and discussions to introduce newly adopted and revised procedures to professionals working in relevant sectors. These events were organized through the Gender Equality Center NGO.

Starting from April 2024, a total of 10 workshops were held, reaching 613 professionals (423F; 190M) from sectors including law enforcement, social protection, immigration, and health.

During these workshop sessions, participants were introduced to the newly adopted and revised procedures. The workshops also provided a platform for professionals from different sectors to discuss how these procedures could be implemented in practice, exchange experiences, and raise challenges they encounter in their daily work.

As a result of these discussions, the newly adopted procedures became more clearly understood and more consistently applied in practice. This has helped relevant institutions provide more coordinated, comprehensive, and effective services to victims of trafficking in persons.



САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн А/17 тушаалаар (хүн худалдаалах гэмт хэрэг) ХХГХ-тэй тэмцэх Салбар дундын хамтарсан баг (СДХБ)-ийг ажлын хэсэг хэлбэрээр манай улсад анх байгуулсан.

Төслийн зүгээс СДХБ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, санаачлан хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн. Төслийн багаас СДХБ-ийн нарийн бичгийн даргаар ажиллан 2022-2025 онд 22 нэгдсэн хуралдаан, 16 дэд багийн хуралдааныг зохион байгуулж, СДХБ-ийн стратеги төлөвлөгөө, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний биелэлтийг хангахад дэмжлэг үзүүлэн ажилласан.



СДХБ-аас ХХГХ-ийн нөхцөл байдлын тайлангуудыг боловсруулах, хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх, форензик ярилцлагыг нутагшуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг хилийн боомтууд дээр хэрэгжүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.

Түүнчлэн, төслийн зүгээс СДХБ-ийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам дээр тусгайлан гаргасан өрөөний тохижилтыг хийж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан.

Харин хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд СДХБ нь албан ёсоор хуульчлагдсан бүтэц болж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/156 тушаалаар шинээр байгуулагдан ажиллаж эхлээд байна.

ХХГХ-ийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх СДХБ байгуулагдсанаар ХХГХ-ийн хохирогч хүүхдэд тусламж үйлчилгээг цаг алдалгүй, уялдаа холбоотойгоор үзүүлэх, тухайн хүүхдийн сэтгэцийн гэмтлийг дахин сэдрээхгүй байх, улмаар эргэн нийгэмшиж хэвийн амьдралдаа ороход нь туслах төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үнэн зөв, түргэн шуурхай явуулахад дэмжлэг болж байгаа юм.



SUPPORT TO THE MULTI-DISCIPLINARY TASK FORCE

The Multi-Disciplinary Task Force (MDTF) to Combat Trafficking in Persons was first established in Mongolia as a working group by the Order A/17 of the Head of the Secretariat of the Coordination Council for Crime Prevention on July 7, 2021.

The project has been actively supporting the MDTF by strengthening its operations, as well as by contributing to the initiatives implemented by the task force. A member of the project team served as the MDTF Secretary and supported the organization of 22 plenary meetings and 16 sub-group meetings between 2022 and 2025. The project also assisted in developing the MDTF's strategic plan and annual action plans, as well as monitoring and reporting on their implementation.



In collaboration with the MDTF, the project supported a number of key initiatives, including the preparation of data driven reports on trafficking in persons in Mongolia, the promotion of victim-centered approaches, the introduction and institutionalization of forensic interviewing, capacity-building trainings and discussions for professionals, and awareness-raising and prevention activities at border crossing checkpoints.

To further support the sustainability of the MDTF, the project also renovated a dedicated office space at the Ministry of Justice and Home Affairs and equipped it with the necessary furniture and equipment.

As part of ongoing legal reforms, the MDTF is now formally institutionalized and re-established under the Order A/156 of the Minister of Justice and Home Affairs, issued on December 16, 2025.

The establishment of the MDTF providing services to child victims of trafficking significantly improves the coordination of assistance and services. It enables timely and integrated support, helps prevent re-traumatization during the response process, and contributes to the child's recovery and reintegration into normal life. At the same time, it supports more efficient and accurate case handling within the criminal justice system.


САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

ХХГХ-тэй тэмцэх Салбар дундын хамтарсан баг (СДХБ) нь Монгол Улсад өмнө нь байгаагүй, шинээр байгуулагдсан бүтэц тул багийн гишүүдийг нэгдсэн ойлголтоор ханган чадавхжуулах нь нэн шаардлагатай чухал ажил юм.

Тиймээс төслийн зүгээс 2022-2024 онд АНУ-ын “Үндэсний хүүхдүүдийн эвсэл” байгууллагатай СДХБ-ийн гишүүдэд цахим сургалт орох болон ганцаарчилсан менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилласан.

Сургалт:

2022 оны 4 сараас 2023 оны 12 сар хүртэл хугацаанд 11 цахим сургалтыг СДХБ-ийн ажиллах зарчим, хохирогч төвтэй аргачлал, хохирогчийг олж тогтоох, үйлчилгээ үзүүлэх, дата мэдээлэл цуглуулах, боловсруулах зэрэг өргөн сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Эдгээр сургалтад СДХБ-ийн 21 (12 эм; 9 эр) гишүүн болон хамаарал бүхий байгууллагуудын 51 (30 эм; 21 эр) мэргэжилтэн хамрагдсан.



30 эрэгтэй



42 эмэгтэй



Менторшип хөтөлбөр:

Хөтөлбөрийн хүрээнд 7 (4 эм; 3 эр) СДХБ-ийн гишүүн АНУ-ын цагдаа, прокурор, хүүхэд хамгааллын зэрэг холбогдох мэргэжилтнүүдтэй нийт 29 цагийн ганцаарчилсан цахим уулзалт хийсэн байна.

СДХБ-ийн гишүүдийг чадавхжуулснаар тэд ХХГХ-тэй тэмцэх талаар илүү цогц ойлголттой болж, илүү нягт хамтран ажиллах болсон бөгөөд СДХБ-ийн үйл ажиллагааны хүрээнд олон ажлыг санаачлан хэрэгжүүлэх үндэс нь болсон юм.

CAPACITY BUILDING FOR THE MULTI-DISCIPLINARY TASK FORCE

As the Multi-Disciplinary Task Force (MDTF) to combat trafficking in persons is a newly established structure in Mongolia, strengthening the capacity of its members and ensuring a shared understanding of its mandate and working principles has been a key priority.



To support this effort, the project partnered with the National Children's Alliance of the United States between 2022 and 2024 to deliver online training and a mentorship program for the MDTF members.

Trainings:

From April 2022 to December 2023, a total of 11 online training sessions were organized covering a wide range of topics, including MDTF operational principles, victim-centered approaches, victim identification, service provision, and data collection and analysis. These trainings were attended by 21 MDTF members (12F; 9M) as well as 51 professionals (30F; 21M) from relevant partner organizations.

Mentorship Program:

As part of the mentorship program, 7 MDTF members (4F; 3M) participated in 29 hours of one-on-one online mentoring sessions with professionals from the United States, including law enforcement officers, prosecutors, and child protection specialists.

Through these capacity building activities, the MDTF members developed a more comprehensive understanding of trafficking in persons and strengthened their collaboration across institutions. This has enabled the task force to initiate and implement a range of coordinated actions in the fight against trafficking in persons.

ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

2022-2023 онд СДХБ-ийн гишүүдийн АНУ-д туршлага судлах аяллыг 2 удаа зохион байгуулсан бол 2025 онд шийдвэр гаргах түвшний албан хаагчдад зориулсан туршлага судлах аяллыг зохион байгууллаа.

2022

2022 оны 08-р сарын 14-21 – СДХБ-ийн 11 гишүүн АНУ руу аялан 3 хүүхэд хамгааллын төвөөр зочлон АНУ-ын Төрийн департаментын ХХГХ-тэй тэмцэх газар, Үндэсний хүүхдүүдийн эвсэл, Поларис ТББ, Дэлхийн зөн, Азийн сан байгууллагуудтай уулзалт хийсэн.

2023

2023 оны 05-р сарын 15-21 – СДХБ-ийн 7 гишүүн, Цагдаагийн ерөнхий газар болон ТББ-ын төлөөлөл АНУ-д зочлон АНУ-ын Төрийн департаментын ХХГХ-тэй тэмцэх газар, 3 хүүхэд хамгааллын төв, Фэйрфакс дүүргийн шүүх болон цагдаагийн байгууллага, Поларис ТББ, Дэлхийн зөн, Азийн сан байгууллагуудтай уулзалт хийсэн.

2025

2025 оны 10-р сарын 10-18 – Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Улсын ерөнхий прокурорын газар, Дээд шүүх, Шүүх шинжилгээний ерөнхий газар зэрэг байгууллагын шийдвэр гаргах түвшний 8 албан хаагчид АНУ-д аялан Балтимор дахь Хүүхэд хамгааллын төв, Ховард дүүргийн Хүүхэд хамгааллын газар, Алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах олон улсын төв, Дэлхийн зөн байгууллагаар зочилсон бөгөөд Азийн сан, АНУ-ын шүүгч болон прокурорын төлөөлөлтэй уулзалт хийсэн.



Төслийн зүгээс аялал бүрийн дараа оролцогчдоос тайлан, хэрэгжүүлэх ажлын танилцуулга авч нягт холбоотой ажилласан. Аяллын мөрөөр олон ажил хийгдсэний нэг нь форензик ярилцлагыг нэвтрүүлэх санаачилга байсан.

STUDY TOURS

In 2022–2023, two study tours to the United States were organized for members of the MDTF. In 2025, another study visit was organized for decision-making level officials from relevant institutions.

August 14–21, 2022 – A delegation of 11 MDTF members visited the United States. During the visit, they toured three Child Advocacy Centers and held meetings with the U.S. Department of State’s Office to Monitor and Combat Trafficking in Persons, the National Children’s Alliance, Polaris Project, World Vision, and The Asia Foundation.

2022

May 15–21, 2023 – Seven MDTF members, together with representatives from the National Police Agency and civil society organizations, visited the United States. The delegation met with the U.S. Department of State’s Office to Monitor and Combat Trafficking in Persons, visited three Child Advocacy Centers, and toured the Fairfax County court and police department. Meetings were also held with representatives from Polaris Project, World Vision, and The Asia Foundation.

2023

October 10–18, 2025 – A group of eight decision-makers from institutions including the Secretariat of the Coordination Council for Crime Prevention, the General Prosecutor’s Office, the Supreme Court, and the National Forensic Agency visited the United States. During the visit, the delegation toured the Baltimore Child Advocacy Center, the Howard County Child Advocacy Center, and the International Centre for Missing & Exploited Children, and met with representatives from World Vision, The Asia Foundation as well as U.S. judges and prosecutors.

2025

Following each study visit, the project team collected reports and proposed follow-up actions from participants and maintained close communication with them. One of the initiatives that emerged from these visits was the introduction of forensic interviewing practices in Mongolia.



ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ӨРӨӨ

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдэд ээлтэй, хохирогчтой төвтэй, сэтгэцийн гэмтэлд суурилсан арга хандлагаар олон улсын стандарт, зөвлөмжийг ханган хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс нийт 8 хүүхдэд ээлтэй мэдүүлэг авах өрөөг цагдаагийн болон хүүхэд хамгааллын байгууллагуудын дэргэд байгуулав.

Тохиромжгүй орчинд хүүхдүүд мэдүүлэг өгөх үед дахин цочрол авах, мэдээллээ нуух, буруу өгөх зэрэг эрсдэл өндөр байсан бол шинэ өрөөнүүд нь нам гүм, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх боломжийг бүрэн хангаж байна. Ингэснээр цагдаа, нийгмийн ажилтан, олон салбарын мэргэжилтнүүд хүүхэдтэй мэргэжлийн, эмзэг байдлыг хүндэтгэсэн орчинд ярилцлага хийх боломжтой болж, хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийн мэдүүлгийн чанар сайжирч, давтан мэдүүлгээс үүдэх сэтгэлзүйн дарамт буурч байна.



Эдгээр өрөөнүүд нь хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдэд ээлтэй хуульт ёсны хүртээмжийг бодитоор бий болгож өгч байгаа юм. Одоо хүүхдүүд хэрэг хянан шийдвэрлэх явцад олон удаагийн оролцоогүйгээр, нэг цэгийн зарчмаар шаардлагатай үйлчилгээ авах, гэмт хэрэгтэнтэй нүүр тулгарахгүй байх, шаардлагатай тохиолдолд онлайн байдлаар оролцох боломж бүрдэв. Мөн прокурор, цагдаа, хүүхэд хамгааллын байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, хэргийг шийдвэрлэх хугацаа богиносох, сэтгэлзүйн эрсдэл буурах, нотлох баримтын чанар сайжрах зэрэг системийн түвшний үр нөлөө илэрч байна.

8 өрөөний байршил:

Цагдаагийн 5 байгууллага (ойролцоогоор 300 сая төгрөг):



НЦУГ – Мөрдөн шалгах газар
(Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар)



Хан-Уул дүүргийн
Цагдаагийн 2-р хэлтэс



Сонгинохайрхан дүүргийн
Цагдаагийн 1-р хэлтэс



ЦЕГ – Эрүүгийн цагдаагийн алба



ЦЕГ – Мөрдөн байцаах алба

Хүүхэд хамгааллын байгууллагын 3 өрөө (ойролцоогоор 200 сая төгрөг):



Чингэлтэй дүүргийн Хүүхэд,
гэр бүлийн хөгжил, хамгааллын
хэлтэс



Хүүхдийн тусламжийн 108
төвийн дэргэдэх түр хамгаалах
байр



Баянзүрх дүүргийн хүүхэд
хамгаалах байр

Эдгээр өрөөг тууштай, хүүхдийн эрхийн мэдрэмжтэйгээр ашиглуулах үүднээс Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх Зөвлөмжийг боловсруулж, өрөө байгуулсан цагдаагийн нэгжүүдийн ойролцоогоор 125 алба хаагчдад Зөвлөмжийг танилцуулах сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн, Улсын Ерөнхий Прокурорын газраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүүхэдтэй ажиллах Зөвлөмжийг гаргахдаа дээр дурдсан Зөвлөмжийн үзэл санаа агуулгыг дэлгэрүүлэн ашигласан нь хүүхэдтэй харилцах хүүхдэд ээлтэй арга зүй цаашид түгээн дэлгэрэхэд чухал алхам болж байна.

Хүүхдэд ээлтэй өрөөнд үйлчилгээ авч буй хүүхдүүдэд зориулсан танилцуулга хэвлүүлж, богино анимешн хэлбэрээр тэдний эрхийг танилцуулсан видео боловсруулан гаргасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн оролцоонд суурилсан, хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргахад дөхөм болж байна.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ
ОРОН ЗАЙД
ТАВТАЙ МОРИЛЛ
Чиний аюулгүй, итгэлтэй сургалт

CHILD-FRIENDLY SPACE

To expand opportunities for child victims to receive services that meet international standards and recommendations—through child friendly, victim centered, and trauma informed approaches in prosecution—a total of eight child friendly interview rooms were established within police and child protection agencies.

Previously, when children provided statements in inappropriate environments, they were at high risk of re traumatization, withholding information, or giving inaccurate testimony. The newly established rooms now provide a quiet, safe, and comfortable environment, fully equipped with the necessary technology and capable of offering psychological support. As a result, police officers, social workers, and multidisciplinary professionals are now able to conduct interviews in a professional and trauma informed way, improving the quality of children’s statements during investigations and reducing the psychological stress associated with repeated interviews.



These rooms have created practical access to child friendly justice within the child protection system. Children can now receive necessary services during prosecution through a one stop approach without multiple appearances, avoid face to face encounters with offenders, and participate online when needed. Additionally, cooperation between prosecutors, police, and child protection agencies has improved, leading to shorter prosecution time, reduced psychological risks, and better quality of evidence—demonstrating a system level impact.





Locations of the 8 Rooms

Five rooms within police agencies (approx. 300 million MNT):



Metropolitan Police Department's Investigation Department (Cybercrime Division)



Division #2, Khan-Uul District Police Department



Division #1, Songinokhairkhan District Police Department



Criminal Police Department of National Police Agency



Investigations Department of National Police Agency

Three rooms under child protection agencies (approx. 200 million MNT):



Chingeltei District Department for Child and Family Development and Protection



Temporary Shelter under the Child Helpline 108 Center



Bayanzurkh District Child Protection Shelter

To ensure consistent and child rights sensitive use of these rooms, a “Guideline for Establishing Child Friendly Spaces in Police Settings” was developed and introduced to approximately 125 officers from the police units where the rooms were established. Furthermore, when the Office of the Prosecutor General developed its guideline on working with children during criminal proceedings, it incorporated and expanded upon the key principles from this Guideline. This marks an important step toward the wider dissemination of child friendly practices for interacting with children.

CPC developed and published a child friendly brochure for children receiving services in the child friendly spaces, and produced a short animated video introducing their rights. These tools are helping to facilitate child participatory and best interest-based decision making during case investigation and prosecution processes.





ХХГХ-ТЭЙ ТЭМЦЭХ ТАСГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ХХГХ-тэй тэмцэх тасгийн үйл ажиллагааг дэмжих, алба хаагчдыг чадавхжуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ХХГХ-тэй тэмцэх тасгийн чадавхыг үнэлэн, ажлын байрны шинжилгээ хийж, зохимжиторонтоо, чадавх бүхий бүтцийн талаар санал, зөвлөмж боловсруулан хүлээлгэн өгсөн. Үнэлгээний үр дүнд Цагдаагийн ерөнхий газраас бүтцийн өөрчлөлт хийн тус тасгийн орон тоог 6-аас 12 болгон нэмэгдүүлсэн.

1

2

Тасгийн үйл ажиллагаанд “Сүмбээ” хиймэл оюун ухаант платформыг нэвтрүүлэн олон нийтийн сүлжээ, веб сайтуудад тусгай түлхүүр үгийн дагуу мониторинг хийх болсноор сэжигтэй зар оруулж буй цахим хаяг, группэд хяналт тавих, шалгах, хаах зэрэг арга хэмжээг шуурхай авч ажилладаг болсон.

3

4

Тасгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн суурин компьютер, зөөврийн компьютер, ухаалаг таблет, принтер зэрэг хэрэгцээт тоног төхөөрөмжийг худалдан авч 2022 оны 3 сард хүлээлгэн өгсөн.

СДХБ-ийн гишүүнийг чадавхжуулах менторшип хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын мөрдөгчтэй хийсэн уулзалтуудад тус тасгийн алба хаагчдыг бүтнээр нь хамруулсан бөгөөд мөн тасгийн алба хаагчдад зориулан ХХГХ-ийн олон улсын нөхцөл байдал, шинээр үүсэн гарч буй төрлүүд, тэдгээртэй тэмцэж байгаа туршлагын талаар сургалтыг 2025 оны 9 сард гадаад мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулсан.

STRENGTHENING THE CAPACITY OF THE ANTI-TRAFFICKING UNIT

The project implemented several activities to support the work and strengthen the capacity of the Anti-Trafficking Unit of the Organized Crime Division of the Criminal Police Department.

The project conducted a capacity assessment and job analysis of the unit and provided recommendations on an appropriate structure and staffing. As a result, the National Police Agency restructured the unit and increased its staff from six to 12 officers.

1

The Sumbee artificial intelligence platform was introduced to support the unit's operations. Through this platform, officers can monitor social media and websites using specific keywords, enabling them to track suspicious advertisements, monitor online accounts and groups, and take timely actions such as investigation and content removal.

2

To further support the unit's work, the project procured and delivered essential equipment, including desktop computers, laptops, tablets, and printers in March 2022

3


Officers of the unit participated in meetings with an investigator from the US as part of the MDTF mentorship program. In addition, in September 2025, a training session was organized with an international expert for the unit's officers, focusing on global trends in trafficking in persons, emerging forms of the crime, and international practices in combating trafficking.

4



ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН

ХХГХ-тэй тэмцэх ажлын хүрээнд уг гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлох олон улсын тайланг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC) 2009 оноос эхлэн гаргаж эхэлсэн ба өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 8 тайлан нийтийн хүртээл болгожээ. Харин АНУ-ын хувьд ХХГХ-ийн тайлан (Trafficking in Persons Report)-г өнгөрсөн 25 жилийн хугацаанд жил бүр боловсруулан гаргасаар иржээ.



2022-2023 онд Хүйсийн тэгш эрх төв ТББ-д хандсан үйлчлүүлэгч/хохилогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт



Тэгвэл Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, чиг хандлага, түүнтэй тэмцэж буй хүчин чармайлтын талаар нэгдсэн тайлан болох “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан”-г 2022 оноос хойш төслийн хүрээнд СДХБ-ийн гишүүдтэй хамтран боловсруулж, нийтийн хүртээл болгож байна. 2019-2021 оныг хамруулсан тайланг 2022 онд, 2022-2023 оныг хамруулсан тайланг 2024 онд, 2024 оныг хамруулсан тайланг 2025 онд тус тус боловсруулан гаргасан. Уг тайлангуудад ХХГХ-ийн нөхцөл байдал, чиг хандлага, уг гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт болон 4P (Prosecution – Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Protection – Хохирогч хамгаалал, Prevention – Урьдчилан сэргийлэх, Partnership – Хамтын ажиллагаа)-ийн хүрээнд тухайн жилүүдийн статистик тоон мэдээлэл болон онцлох мэдээллийг багтаадаг.

Энэхүү тайланг боловсруулан гаргадаг болсон нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хийж буй ажлуудаа дотооддоо нэгтгэн дүгнэж, хамтын ажиллагааг сайжруулах, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлон төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

ANNUAL DATA-DRIVEN REPORTS

As part of global efforts to combat trafficking in persons, international reports analyzing the situation and trends of the crime have been published for many years. The United Nations Office on Drugs and Crime (UNODC) has produced global reports on trafficking in persons since 2009, publishing a total of eight reports to date. Similarly, the U.S. Department of State has released its annual Trafficking in Persons Report for the past 25 years.

In Mongolia, a comprehensive national report titled “Data-Driven Report on Combatting Trafficking in Persons in Mongolia” has been produced since 2022 under the CPC project, in collaboration with members of the MDTF.

So far, three reports have been published:

The 2019–2021 report, released in 2022


The 2022–2023 report, released in 2024

The 2024 report, released in 2025

These reports present an overview of the situation and trends of trafficking in persons in Mongolia, developments in the legal framework, and key statistics and highlights related to the 4Ps approach: Prosecution, Protection, Prevention, and Partnership.

The preparation and publication of this report has become an important tool for consolidating national efforts to combat trafficking in persons, strengthening coordination among relevant stakeholders, and identifying priority actions for future work.

Figure 19. Number of victims who received services from the Gender Equality Center in 2022-2023



ҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА: АСУУДАЛ ШИЙДЭЛ



ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: АСУУДАЛ, ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төсөл хэрэгжих хугацаанд 2022 оноос эхлэн жил бүр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албатай хамтран “Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал шийдэл хэлэлцүүлэг”-ийг зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэг нь цагдаа, прокурор, шүүх засаглалын байгууллагын төдийгүй хүүхэд хамгааллын салбарын байгууллагууд, өмгөөлөгчдийн төлөөлөл нэг дор цугларч тулгарч буй асуудлаа хэлэлцэн, шийдэл эрэлхийлдэг талбар болж чадсан.

Нийт дөрвөн удаа зохион байгуулсан энэхүү хэлэлцүүлгээр ХХГХ-ийн нөхцөл байдал, чиг хандлага, тулгарч буй асуудал дээр ярилцахаас гадна форензик ярилцлагын аргачлалыг нутагшуулах, хүүхдэд ээлтэй өрөөний ашиглалт, албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирол нөхөн төлөлт зэрэг сэдвүүдийг сонгон авч тусгайлан хэлэлцсэн.

Жил бүрийн хэлэлцүүлгийн үр дүнд зөвлөмж боловсруулан гаргадаг бөгөөд зөвлөмжийг Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлд танилцуулан, хэрэгжилтэд нь дэмжлэг үзүүлж ирсэн. Тухайлбал, хэлэлцүүлгийн зөвлөмжид дурдсаны дагуу Эрүүгийн хуулийн тодорхой заалтууд дээр харьцуулсан судалгаа хийж, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал хүргүүлэх, албадан хөдөлмөрийн талаар нарийвчилсан судалгаа хийх, шүүгч, хууль ёсны төлөөлөгч, цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчид зэрэг тодорхой зорилтот бүлэгт зориулсан сургалтыг зохион байгуулах зэрэг ажлыг төслийн зүгээс хэрэгжүүлсэн.

ANNUAL PROSECUTION WORKSHOPS

Since 2022, the project has organized the annual Prosecution Workshop in collaboration with the Secretariat of the Coordination Council for Crime Prevention. The workshop serves as a platform where representatives from the police, prosecution, judiciary, child protection sector, and attorneys come together to discuss challenges and explore solutions.

A total of four workshops were organized during the project period. In addition to discussing the situation and trends of trafficking in persons and related crimes, the workshops focused on specific topics such as the introduction of forensic interviewing practices, the use of child-friendly rooms, the detection and prosecution of forced labor and labor exploitation crimes, and compensation for victims of trafficking and sexual exploitation.

Each workshop resulted in a set of recommendations, which were presented to the Sub-Council on Combating and Preventing Trafficking in Persons. The project also supported the implementation of these recommendations. For example, follow-up actions included conducting comparative legal research on certain provisions of the Criminal Code and proposing amendments, carrying out in-depth research on forced labor, and organizing targeted trainings for specific groups, including judges, legal representatives, and psychologists working within law enforcement institutions.



ХАМГААЛАХ БАЙРНЫ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хамгаалах байрны үйлчилгээ үзүүлдэг Хүйсийн тэгш эрх төв болон Талита Ази ТББ-ын дэргэдэх 4 хамгаалах байр (тус бүр 2)-ыг хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулан засварлаж хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чадавхыг нь нэмэгдүүлэв. Улмаар Талита Ази төрийн бус байгууллагатай 2021 оны 4-р сараас 2024 оны 3-р сар, Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай 2022 оны 1-р сараас 2024 оны 4-р сар дуустал хугацаанд хүүхдэд хамгаалах байрнаас үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ, хувь хүний хөгжлийн хөтөлбөр, хууль зүйн туслалцаа үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, эргэн нийгэмшүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлэхэд шууд дэмжлэг үзүүлэв. Төслийн хугацаанд эдгээр төрийн бус байгууллагуудаар дамжуулан насанд хүрээгүй 59 хохирогч үйлчилгээ авсан.

Төслийн дэмжлэгтэйгээр төрийн байгууллагын дэргэд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нөхөн сэргээх төвийг 2024 оны 10-р сард байгуулж ашиглалалтад оруулсан. Тус төвөөр үйлчлүүлж буй хүн худалдаалах гэмт хэргийн 8 хохирогч хүүхдийн эргэн нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүүхдүүдийг мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулснаар гоо сайханч, үсчин, маникюр зэрэг мэргэжлээр суралцаж, сертификат авсан. Хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн хүүхдүүдийн зарим нь өөрийн хүслээр мэргэжлээрээ ажиллаж эхлэн нийгэмд хөл нийлүүлэн амьдарч байна.



STRENGTHENING THE CAPACITY OF SHELTERS



To enhance trauma-informed and child friendly services for victims of trafficking in persons (TIP), four shelters operated by the Gender Equality Center and Talita Asia (two each) were renovated and furnished to be child friendly, increasing their capacity to provide services to child victims. Furthermore, from April 2021 to March 2024 with Talita Asia, and from January 2022 to April 2024 with the Gender Equality Center, the project directly supported the provision of services to children in shelters. These services included health care, psychological counseling, psychotherapy, personal development programs, legal assistance, educational support, and reintegration services. During the project period, a total of 54 child victims received services through these NGOs.

With project support, a child rehabilitation center for victims of sexual violence was established under a government agency and became operational in October 2024. The project has supported the reintegration of eight child victims of trafficking in persons (TIP) who received services at this center. These children were enrolled in vocational training programs—such as cosmetology, hairdressing, and manicure—and successfully obtained certificates. Some of the children who have reached the legally permitted working age have voluntarily begun working in their trained professions and are steadily integrating into society.



ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАДАВХЖУУЛАХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх арга зүйг олон улсын сайн туршлага, үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн олон улсын болон дотоодын зөвлөхүүдийн хамтын оролцоонд суурилан боловсруулан гаргав. Тус арга зүйг түгээх 40 сургагч багш нарыг бэлтгэснээр арга зүйг цаашид түгээх боломж нөөцийг бүрдүүлсэн.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх гарын авлага боловсруулан бэлгийн хүчирхийлэл мөлжлөгийн хохирогч хүүхэдтэй ажиллаж буй сэтгэл зүйчдээр дамжуулан гарын авлагыг нутагшуулах ажлыг гүйцэтгэсэн. Гарын авлагын дагуу сэтгэл зүйчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж ХГБХХЕГ болон ЦЕГ-ийн харьяа байгууллагын 51 мэргэжлийн сэтгэл зүйчдийг сургалтад хамруулж, сургалтын дараах менторшип үзүүлэн ажиллав. Тус сургалтын цахим модулийг гарган ХГБХХЕГ-ийн цахим талбарт байршуулсан. Мөн төрийн болон төрийн бус байгууллагын 85 нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг хохирогч хүүхдэд урлагаар сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх арга зүйд сургасан.



Эдгээр арга зүйг нэвтрүүлснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж бодитоор сайжирч, мэргэжилтнүүд хүүхдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хамгааллын үйлчилгээг илүү үр дүнтэй үзүүлэх чадавх нэмэгдэж байна.



CAPACITY BUILDING OF CHILD PROTECTION SERVICE

A trauma informed comprehensive service methodology for child victims of trafficking in persons was developed based on international best practices and aligned with national legislation, through close collaboration between international and national experts. To support further dissemination, 40 trainers were prepared to deliver this methodology nationwide.

A counseling manual for providing psychological support to child victims of trafficking in persons was also developed, and its localization was carried out through psychologists working with child survivors of sexual violence and exploitation. Based on the manual, a training was organized for psychologists,



reaching 51 professionals from the GACFDP and the National Police Agency. Post training mentorship was provided to strengthen application in practice. An online training module was developed and uploaded to the GACFDP's digital platform. Additionally, 85 social workers and psychologists from governmental and non governmental organizations were trained on delivering art therapy for child victims.

By introducing these methodologies, the quality and accessibility of services for child victims of trafficking have measurably improved, and professionals are now better equipped to provide trauma informed, victim centered, and child friendly protection services more effectively.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА СУРГАЛТ

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2023-2024 оны хооронд нийт 21 аймагт болон Улаанбаатарт 9 дүүргийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, 785 шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагчийг сургасан. Эдгээр сургалтад 135 шүүгч (58 эр, 77 эм), 168 прокурор (71 эр, 97 эм) болон 482 цагдаагийн алба хаагч (381 эр, 101 эм) тус тус хамрагдсан.

Сургалтын гарын авлагыг олон улсын зөвлөх, дотоодын эрдэмтэн судлаачид хамтран боловсруулсан ба нийт 10 модулийн хүрээнд ХХГХ-ийн тухай ойлголт, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтууд, хохирогчийг олж илрүүлэх, таньж тогтоох, мэдүүлэг авах онцлог, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, олон талт хамтын ажиллагаа, кибер орчныг ашиглан үйлдэгдэж буй хэлбэрүүд, мөн уг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, яллах болон шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа сэдвүүдийг хамруулсан. Сургалтыг үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн 19 шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч болон Дотоод хэргийн их сургуулийн багш нар хамтран заасан.

Энэхүү сургалт нь лекц болон дадлага ажлыг хослуулсан хэлбэрээр явагдсан бөгөөд цагдаа, прокурор, шүүгч нар хамтран оролцож, ойлголтоо нэгтгэх, уялдаа холбоогоо сайжруулах боломжийг бүрдүүлснээрээ үр дүнтэй болсон.





TRAINING ON INVESTIGATING AND PROSECUTING TRAFFICKING IN PERSONS CASES WITH VICTIM-CENTERED AND CHILD-FRIENDLY APPROACHES

A two-day training titled “Investigating and Prosecuting TIP Cases with Victim-Centered and Child-Friendly Approaches” was organized for government officials across all 21 provinces and in Ulaanbaatar for 9 districts between 2023 and 2024. In total, 785 participants including judges, prosecutors, and police officers participated in the training. This included 135 judges (58M, 77F), 168 prosecutors (71M, 97F), and 482 police officers (381M, 101F).

The training handbook was jointly developed by international and national consultants. It consisted of 10 modules covering topics such as an overview of human trafficking crimes; relevant international and national legal frameworks; identification and recognition of victims; specific considerations when interviewing victims; assistance and services provided to victims; multi-stakeholder cooperation; forms of trafficking committed in cyberspace; and the processes of detecting, investigating, prosecuting, and adjudicating human trafficking cases. The training was delivered by 19 judges, prosecutors, police officers and professors from the University of Internal Affairs who had been trained as national trainers.

The training combined lectures and practical exercises and was effective because police officers, prosecutors, and judges participated together, fostering shared understanding and improved coordination.



КИБЕР ОРЧИНД ҮЙЛДЭГДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ СУРГАЛТ

“Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сургалтын хөтөлбөрийг Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Б.Батаа боловсруулан 2025 оны 12-р сард Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн сургалтын хөтөлбөрийн хороогоор орж батлагдсан.



Түүнчлэн төслийн зүгээс Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академитай хамтран шүүгчдэд зориулсан “Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт нэг өдрийн сургалтыг 2026 оны 1-р сарын 15, 22, 30-ны өдрүүдэд зохион байгуулж, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, орон нутгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн нийт 95 шүүгчийг (34 эр, 61 эм) сургасан.

Шүүгчид энэхүү сургалтын үр дүнд ХХГХ-ийг кибер орчинд хэрхэн үйлдэж байгаа, мөрдөгч нар тухайн үйлдлийг хэрхэн баримтжуулдаг, тэдний бэхжүүлсэн цахим нотлох баримтыг хэрхэн үнэлэх, үнэн зөв эсэхийг нягтлах, шинэ төрлийн үйлдлийн арга, хэлбэрийг тухайн гэмт хэргийн шинжтэй холбож тайлбарлах буюу зүйлчлэхэд анхаарах асуудлыг цогцоор нь таньж мэдсэн ба шүүн таслах ажиллагаанд хууль хэрэглээний нэгдмэл ойлголттой болоход нэмэртэй сургалт болсон.

TRAINING ON ADJUDICATION OF CYBER-FACILITATED TRAFFICKING IN PERSONS CASES

A training program on “Adjudication of Cyber-Facilitated TIP Cases” was developed by Judge B.Bataa of the District Criminal and Civil First Instance Simplified Procedure Circuit Court, and the training program was approved in December 2025 by the Training Program Committee of the Judicial Academy.



In collaboration with the Judicial Academy, one-day training designed for judges named “Adjudication of Cyber-Facilitated TIP Cases” was organized on January 15, 22, and 30, 2026. A total of 95 judges (34M, 61F) participated, including judges from the Capital City Court of Criminal Appeals, District Court of First Instance for Criminal Cases, and Provincial Courts of First Instance and Appeal for Criminal and Civil Cases.

As a result of the training, judges gained a comprehensive understanding of how human trafficking crimes are committed through cyberspace, how investigators document such cases, and how to assess and verify the reliability of digital evidence collected during investigations. The training also addressed emerging methods and forms of trafficking and highlighted key considerations for interpreting these acts in relation to the legal elements of the crime. Overall, the training contributed to strengthening a shared and consistent understanding of legal application in judicial proceedings.



ФОРЕНЗИК ЯРИЛЦЛАГА

2022 онд СДХБ-ийн гишүүд АНУ-д туршлага судлах аялалд хамрагдаж Форензик ярилцлагыг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээтэй шилдэг туршлага гэж үзсэн. Форензик ярилцлага гэдэг нь тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн насанд хүрээгүй хохирогчийг сэтгэцийн гэмтэлд дахин орохоос сэргийлж, хүүхдэд ээлтэй, хохирогч төвтэй байдлаар ярилцах аргачлал бөгөөд мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, насанд хүрээгүй хохирогчид туслалцаа, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр гадаадын улс орнуудад хэрэгжүүлдэг шилдэг туршлага юм.

Үүний дагуу Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ)-ын хүсэлтээр Форензик ярилцлага хийх арга барил эзэмшүүлэх анхны сургалтыг АНУ-ын Мэрилэнд мужийн Балтимор хотын “Center for Hope” Хүүхэд хамгааллын төвтэй хамтран 2023 оны 1 сард зохион байгуулсан. Тус сургалтад УЕПГ, Нийслэлийн прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар болон ТББ-уудаас нийт 21 хүн оролцсон. Энэхүү сургалтын үр дүнд УЕПГ-аас 2023 оны 5 сард “Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн насанд хүрээгүй гэрч, хохирогчтой сэтгэцийн гэмтэлд суурилсан хандлагаар хэрхэн харилцах, тэдгээрээс мэдүүлэг авахад анхаарах асуудлын талаар” зөвлөмжийг гарган прокурор, мөрдөгч нарт хүргүүлсэн.



Форензик ярилцлагын үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг 2024 оны 3 сард зохион байгуулж, цагдаагийн байгууллагаас 15, нийгмийн салбараас 13 хүн сургагч багшаар бэлтгэгдсэн. Сургагч багш нараар дамжуулан цагдаагийн алба хаагч нарт форензик ярилцлагын сургалтыг хийсэн ба 107 (39 эр, 68 эм) алба хаагчдыг хамруулсан. Эдгээр сургалтуудын үр дүнд мөрдөгч нар форензик ярилцлага гэж юу болох, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа, асуултын төрлүүд, форензик ярилцлагын 10 үе шатанд суралцаж энэхүү аргын дагуу хэрхэн хохирогч хүүхдээс мэдүүлэг авах дадлага ажлуудыг хийж туршлагажсан.

FORENSIC INTERVIEW

In 2022, members of the MDTF participated in a study visit to the United States, where they identified forensic interviewing as a best practice worth introducing in Mongolia. Forensic interviewing is a method in which a specially trained professional conducts interviews with minor victims in a child-friendly and victim-centered approach, aiming to prevent re-traumatization. It is widely used in many countries as an effective practice for conducting investigations and for providing appropriate assistance and services to child victims.

Following this, at the request of the General Prosecutor's Office, the first training on forensic interviewing techniques was organized in January 2023 in cooperation with Center for Hope, a Baltimore based child advocacy center in Maryland, the US. A total of 21 participants from the National Police Agency, General Prosecutor's Office, the Capital City Prosecutor's Office, and non-governmental organizations attended the training. As a result, in May 2023, the General Prosecutor's Office issued a guideline named "Communication and Interview with Child Victims and Witnesses of Trafficking in Persons, Sexual Exploitation and the Crimes against Sexual Freedom and Inviolability Based on Trauma-Informed Approach," which was distributed to prosecutors and police officers.

Training of trainers on forensic interviewing was organized in March 2024, during which 28 trainers were prepared, including 15 police officers and 13 professionals from the social sector. Through these national trainers, forensic interviewing training was subsequently delivered to 107 police officers (39M, 68F).

As a result of these trainings, police officers gained a clear understanding of forensic interviewing, victim-centered investigative approaches, different types of questioning, and the ten stages of forensic interviewing. They also participated in practical exercises on how to interview child victims in accordance with this methodology, thereby strengthening their practical skills and experience.



МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ АРГА БАРИЛ, ХАНДЛАГА, ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ДАВАН ТУУЛАГЧ ХҮҮХЭДТЭЙ СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛААР АЖИЛЛАХ НЬ СУРГАЛТ

“Мөрдөн шалгах ажиллагааны хохирогч төвтэй арга барил, хандлага” сэдэвт 3 удаагийн сургалтыг 2024 оны 4 сарын 2, 3, 4-ний өдрүүдэд олон улсын мэргэжилтнүүд Монгол Улсад ирж зохион байгуулсан ба нийт 70 цагдаагийн алба хаагчийг сургасан (32 эр, 38 эм).

Сургалтын хүрээнд гэмт хэргийн улмаас сэтгэцийн ноцтой гэмтэл, хямралд орсон хүүхэд болон насанд хүрсэн хохирогчийн нийтлэг илэрхийлдэг зан авир, хандлагыг хэлэлцэж, тэдний итгэлийг олж авах, стрессийг бууруулах, улмаар хэрэгт ач холбогдолтой мэдээллийг үр дүнтэй олж авах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хохирогч төвтэй арга барилыг танилцуулж, зааж сургасан.



Сургалтын үр дүнд алба хаагчид хүүхэд нь наснаасаа хамаараад сэтгэцийн гэмтэл учруулсан үйл явдлыг эргэж санах, дүрслэх чадвар нь өөрчлөгддөг талаар болон ярилцлагын явцад асуулт тавих ухаалаг арга замд суралцаж, сэтгэцийн гэмтлийг харгалзсан арга барил болон хүүхдийн өсөлт хөгжлийн өөрчлөлтийн талаарх мэдлэгээ ашиглан олон төрлийн тохиолдол дээр дүрд тоглох аргаар нас насны хохирогч хүүхэдтэй ярилцлага хийх дадлага хийснээрээ онцлогтой. Мөн алба хаагч нар сэтгэцийн гэмтлийн үйл явдлын талаар сонсож цочирдох, дам байдлаар сэтгэцийн гэмтэлд өөрсдөө өртөх зэргээс урьдчилан сэргийлэх, зохицуулж даван туулах стратегид суралцсан.

Хөөрхөн зүрх ТББ-тай хамтран “ХХГХ-ийн хохирогч, даван туулагч хүүхэдтэй сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар ажиллах нь” сэдэвт сургалтыг 2024 оны 5 сарын 15-17, 24-ний өдрүүдэд зохион байгуулж нийт 117 оролцогчийг хамруулсан. Үүнд 57 цагдаа (57 эр), 36 прокурор (36 эм), 24 шүүгч (5 эр, 19 эм) оролцсон. Сургалтад оролцогчид сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, үр дагавар, хохирогч, даван туулагчтай сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмаар хэрхэн ажиллах, юунд анхаарах зэрэг сэдвийн хүрээнд мэдлэгээ дээшлүүлсэн.

TRAINING ON A VICTIM-CENTERED APPROACH TO CRIMINAL INVESTIGATIONS / TRAUMA-INFORMED APPROACHES FOR INTERVIEWING CHILD VICTIMS OF TRAFFICKING IN PERSONS



Three sessions of training on “Victim-Centered Approach to Criminal Investigations” were held on April 2, 3, and 4, 2024, led by international experts. A total of 70 police officers (32M, 38F) were trained.

The training familiarized participants with common behaviors and attitudes of children and adult victims experiencing severe psychological trauma or distress due to a crime. It introduced and taught a victim-centered approach designed to build trust, reduce stress, and create conditions for effectively obtaining information critical to the case.



As a result of the training, officers learned that a child’s ability to recall and describe traumatic events can vary depending on their age, and they practiced questioning techniques during interviews. Using a trauma-informed approach and knowledge of child development, officers engaged in role-playing exercises with children of different ages to practice interviewing victims with a victim-centered approach. The training also emphasized strategies for police officers to prevent secondary trauma, manage emotional reactions when hearing about traumatic events, and cope with indirect exposure to psychological trauma.

In collaboration with the Beautiful Hearts NGO, a training on “Trauma-Informed Approaches for Engaging with Child Victims of TIP” was conducted on May 15–17 and 24, 2024. A total of 117 participants attended, including 57 police officers (57M), 36 prosecutors (36F), and 24 judges (5M, 19F). Participants enhanced their knowledge on topics such as the general concept of psychological trauma, the consequences of trauma, and how to work with victims and survivors using a trauma-informed approach, including key considerations to keep in mind during the process.

КИБЕР ОРЧНЫГ АШИГЛАЖ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА СУРГАЛТ

“Кибер орчныг ашиглаж үйлдсэн ХХГХ-ийн мөрдөн шалгах ажиллагаа” сэдэвт 2 өдрийн сургалтыг 2024-2025 оны хооронд бүсчилсэн байдлаар нийт 9 удаа хийж 21 аймаг, 9 дүүргийн нийт 255 цагдаагийн алба хаагч (231 эр, 24 эм), 101 прокурорыг (46 эр, 55 эм) хамруулсан.

Сургалтын гарын авлагыг дотоодын зөвлөхүүд 4 бүлгийн хүрээнд боловсруулсан ба сургалтын үр дүнд цагдаа болон прокурор нар ХХГХ-ийн ерөнхий ойлголт, чиг хандлага, кибер орчныг ашиглан үйлдэгдэж буй ХХГХ-ийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлогийн тухай мэдлэгт суралцахаас гадна нээлттэй, хаалттай эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, олон төрлийн программ хангамжуудыг ашиглаж кибер нотлох баримт, тоон ул мөр бэхжүүлэх зэрэгт практик дасгал ажлуудаар дамжуулан ур чадвараа дээшлүүлсэн.

TRAINING ON INVESTIGATING CYBER-FACILITATED TRAFFICKING IN PERSONS CASES

A two-day training on “Investigating Cyber-Facilitated TIP Cases” was conducted in a series of regional sessions nine times between 2024 and 2025. The training involved participants from all 21 provinces and 9 districts, including 255 police officers (231M, 24F) and 101 prosecutors (46M, 55F).

The training handbook with four chapters was developed by local experts. As a result of the training, police officers and prosecutors enhanced their knowledge of the general concepts and trends of human trafficking, as well as the specific features of detecting and investigating cyber-facilitated trafficking in persons cases. In addition, through practical exercises, participants strengthened their skills in collecting information from open and closed sources, and in identifying, securing, and preserving cyber evidence and digital traces using various software tools.



ХИЛ ДЭЭРХ СУРГАЛТ

2024-2025 онд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Даян боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд боомт, Дорнод аймгийн Хавирга, Баянхошуу боомт, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар боомт, Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомт дээр ажилладаг нийт 396 (228 эр, 168 эм) хил хамгаалах алба, гадаадын иргэн, харьяатын алба, гаалийн байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулсан. Сургалтын агуулгад ХХГХ-ийн талаарх ойлголт, чиг хандлага, нөхцөл байдал, хилийн боомтуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд анхаарах асуудал зэрэг сэдвүүд багтсан.



TRAINING AT BORDER CHECKPOINTS

In 2024–2025, a total of 396 government officials (228 male, 168 female) from the Border Protection Agency, Immigration Agency, and Customs Authority were trained at several border checkpoints, including Tsagaannuur and Dayan checkpoints in Bayan-Ulgii Province; Zamiin-Uud checkpoint in Dornogovi Province; Khavirga and Bayankhoshuu checkpoints in Dornod Province; Altanbulag and Sukhbaatar checkpoints in Selenge Province; and Gashuunsukhait checkpoint in Umnugovi Province.

The training covered topics such as basic TIP understanding, trends and current situation, the conditions of border checkpoints and future trends, and key considerations when allowing children to cross the Mongolian border.



ХОХИРОГЧИЙГ ТАНЬЖ ИЛРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр баталсан зааврын дагуу холбогдох албан хаагчдыг чадавхжуулах сургалтуудыг 2023-2025 онуудад үе шаттай зохион байгуулав.

Үүнд:

- 2023 оны 6-р сард эрүүл мэндийн салбар, тэр дундаа эх барих эмэгтэйчүүдийн эмч нийт 150 албан хаагч нарт,
- 2023 оны 9-р сард 108 хүүхдийн шуурхай тусламжийн төвийн 30 гаруй албан хаагч нарт,
- 2023 оны 10-р сард төслийн хүрээнд ажиллаж буй 5 дүүргийн гэрээр айлчлагч хөтөлбөрийн 200 гаруй сайн дурынханд,
- 2024 оны 2-3-р саруудад Чингис хаан ОУНБ дээрх иргэний агаарын тээврийн компаниудын зорчигч бүртгэл үйлчилгээний ажилтнууд, хил хамгаалах болон цагдаагийн ажилтнууд, иргэний нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын албаны нийт 400 гаруй албан хаагчдад,
- 2025 оны 5-р сард Улаанбаатар төмөр замын Зорчигч вагон депогийн зорчигч үйлчилгээний нийт 136 ажилтан, албан хаагчдад,



Эдгээр сургалт нь үйлчилгээнд гардан ажилладаг албан хаагчдын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болох эрсдэл бүхий тохиолдлуудыг таних, илрүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад холбон зуучлах зохих мэдлэгийг хүргэж чадсан.

CAPACITY BUILDING OF FRONTLINE WORKERS ON IDENTIFICATION OF VICTIMS OF TRAFFICKING

In accordance with the Minister of Labor and Social Protection's guideline issued on 5 April 2022 on identifying victims of trafficking in persons, a series of capacity building trainings for relevant frontline personnel were organized in phases from 2023 to 2025.



These included:

- June 2023: Training for 150 health-sector staff, including local obstetricians;
- September 2023: Training for more than 30 staff of the 108 Child Helpline Emergency Response Center;
- October 2023: Training for over 200 volunteers of the Home Visitor Program operating in five districts under the project;
- February–March 2024: Training for more than 400 personnel at Chinggis Khaan International Airport, including airline check in and passenger service agents, border protection officers, police officers, and civil aviation security staff;
- May 2025: Training for 136 employees of the Ulaanbaatar Railway Passenger Car Depot's passenger service division;

These trainings strengthened the ability of frontline personnel to identify potential victims of trafficking in persons and to refer them to the appropriate authorities when necessary.





ХИЛ ДЭЭРХ ДАМЖИН ӨНГӨРӨХ АЖИГЛАЛТ

Дамжин өнгөрөх ажиглалт нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх явцад эрсдэлд буй зорчигчдыг таньж тогтоох, тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой олон улсад туршигдсан аргачлал юм. Дамжин өнгөрөх ажиглалтыг хэрэгцээ шаардлагаас хамааран хилийн бүс, зорчигч тээвэр, галт тэрэгний зогсоол, нисэх онгоцны буудал гэх зэрэг газруудад хэрэгжүүлдэг.



Төслийн хүрээнд Анбаунд Монгол ТББ-тай хамтран 2022 оны 6-р сараас 2025 оны 11-р сар хүртэлх хугацаанд Чингис Хаан олон улсын нисэх буудал, Замын-Үүд, Алтанбулаг автозамын боомтуудад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэн “Хил дээр дамжин өнгөрөх ажиглалт”-ыг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд нийт 14,163 зорчигчоос асуумж авч урьдчилан сэргийлэх мэдээлэл өгсөн бөгөөд 276 зорчигчдыг эрсдэлд байж болзошгүй гэж тогтоож, үүнээс 116 зорчигч аяллаа зогсоосон (үүнээс 82 хүүхэд) бол, 20 зорчигчийг холбогдох байгууллагуудад холбон зуучилсан.

2025 оны 12 сарын 3-нд хил дээрх дамжин өнгөрөх үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үр дүнд оролцогчид хил дээрх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, эрсдэлтэй хүүхдийг илрүүлж хамгаалах боломжийг нэмэгдүүлэхэд төрийн бус байгууллагуудын оролцоо чухал байгааг онцолж, байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулах, хил хяналтын мэдээллийн цахим системийг шинэчлэх, хил дээр ажиллах алба хаагчдад зориулсан хамтарсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хүүхдэ хилээр нэвтрэх үед бүрдүүлэх баримт бичгүүдийг цахимжуулах талаар санал солилцсон. Эдгээр арга хэмжээ нь хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг бууруулах, хариу үйлдлийн механизмыг сайжруулах, Монгол Улсын хил дээр хүүхэд хамгааллын илүү уялдаатай, цогц хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах юм.



BORDER MONITORING

Border monitoring is an internationally tested approach aimed at identifying travelers at risk of trafficking in persons, and preventing and protecting them from this crime. Depending on context and need, border monitoring is implemented in locations such as border zones, passenger transport hubs, train stations, and airports.

Within the project, in partnership with Unbound Mongolia NGO, “Border Monitoring” was implemented from June 2022 to November 2025 at Chinggis Khaan International Airport, and at the Zamiin-Uud and Altanbulag road border checkpoints, by providing awareness-raising information to prevent trafficking in persons. During this period, the project collected surveys and provided prevention information to a total of 14,163 travelers, identified 276 travelers as potentially at risk, of whom 116 travelers (including 82 children) decided to stop their travel, and 20 travelers were referred to relevant authorities.

On December 3, 2025, a round-table discussion was organized to review the results of the border monitoring activities. Participants emphasized the importance of strengthening prevention efforts at the border and increasing the capacity to identify and protect children at risk, highlighting the essential role of civil society organizations. They also exchanged



views on improving inter-agency coordination, upgrading the electronic border control information system, developing a joint training program for border officers, and digitizing documentation required for children crossing the border. These measures contribute to reducing the risks of trafficking, improving response mechanisms, and fostering a more coordinated and comprehensive child protection approach at Mongolia’s borders.

ВИДЕО ХИЧЭЭЛҮҮД

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт 10 модуль бүхий шүүгч, прокурор, цагдаа нарт зориулсан сургалтыг видео хичээл болгон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газар болон Дотоод хэргийн их сургуульд хүлээлгэн өгсөн.

Мөн “Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт прокурор, цагдаа нарт зориулсан 4 модуль бүхий сургалтыг видео хичээл болгон холбогдох төрийн байгууллагуудад хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон байна.


Тус видео хичээлүүд нь тухайн байгууллагуудын цахим сургалтын системд байрласнаар албан хаагчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бие даан суралцах боломжтой болж байгаа ба эдгээр сургалтыг өмнө нь танхимийн хэлбэрээр зохион байгуулахад хамрагдаж чадаагүй болон шинээр ажилд орсон алба хаагчид үзэх боломжтой болж байна.

VIDEO TRAINING COURSES

A 10-module training on “Investigating and Prosecuting TIP Cases with Victim-Centered and Child-Friendly Approaches” for judges, prosecutors, and police officers was developed as video training courses and handed over to the Judicial Academy, the Training and Research Institute of the General Prosecutor’s Office, the National Police Agency, and the University of Internal Affairs.

In addition, a four-module video training course on “Investigating Cyber-Facilitated TIP Cases” for prosecutors and police officers was developed and prepared for handover to the respective government institutions.

By being uploaded to the e-learning systems of the respective institutions, these video training courses enable government officials to study and learn independently regardless of time and location. They also allow officers who were unable to participate when the trainings were previously conducted in in-person format, as well as newly recruited employees, to access and benefit from the training.



ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛӨЛТИЙН ТАЛААР СУДАЛГААНУУД

Төслийн хүрээнд 2024 онд Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-тай хамтран гэмт хэргийн хохирлын нөхөн төлөлтийн талаар дараах хоёр судалгааг хийж гүйцэтгэсэн.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн төлбөр олгох талаар олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах” судалгаа. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нөхөн төлбөр авах асуудлаар уг судалгааны ажлыг хийхийг зорьсон ба ингэхдээ олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, НҮБ-ын тунхаглал, зарчим, удирдамжид суурилан, АНУ, Франц, Нидерланд, ХБНГУ, Япон зэрэг улсуудын сайн туршлагуудыг харьцуулан судалсны үр дүнд Монгол Улсад хэрэгжүүлэх зохистой арга хэлбэрийг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулсан.

“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлж буй практик” судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хохирогчид учирсан хохирлыг барагдуулахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар ажиллагааг хийж байгаа, хохирол төлбөрийг аль шатанд нь, хэрхэн барагдуулж байгаа, хохирогч, түүний эрх ашгийг хамгаалж байгаа талуудын хийж болох ажиллагаа, хохирогчид хохирол, нөхөн төлбөрөө барагдуулахад шаардлагатай мэдээллийг хэрхэн өгч байгаа зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулсан.

STUDIES ON COMPENSATION FOR VICTIMS OF CRIME

In 2024, the project collaborated with the Gender Equality Center NGO to conduct two studies focusing on compensation for victims of trafficking in persons crimes.


“International Good Practices in Providing Compensation to Victims of Trafficking in Persons, Including Child Victims” was conducted. This study examined international best practices on providing compensation to victims of trafficking in persons. Drawing on international human rights treaties, UN declarations, principles, and guidelines, the research analyzed the experiences of countries such as the United States, France, the Netherlands, Germany, and Japan. Based on this comparative analysis, the study identified possible approaches that could be adapted and implemented in Mongolia and developed a set of recommendations.

“Practices of Compensating Crime Victims Using Assets and Proceeds Derived from a Crime” was conducted. This study explored how compensation for victims, particularly child victims of trafficking in persons, is addressed in practice. The research examined the procedures under the Criminal Procedure Law related to recovering damages from assets and proceeds obtained through criminal activities. It also analyzed at which stages of the criminal process compensation is provided, how damages are recovered, what actions can be taken by institutions and parties protecting the interests of the victims, and how victims are informed about their rights and opportunities to obtain compensation.

ДАТА МЭДЭЭЛЛИЙН САНГ САЙЖРУУЛАХ

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ХХГХ-тэй тэмцэх тасгийн ашигладаг хуучин дата мэдээллийн сан нь тус тасгийн үйл ажиллагааг бүрэн хамраагүй, мэдээлэл бүрэн орох боломжгүй бөгөөд системийг нэмэлтээр хөгжүүлэх боломжгүй зэрэг асуудалтай байсан. Тиймээс уг системийг шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг бэлтгэх зорилгоор “ХХГХ-тэй тэмцэх тасгийн үйл ажиллагааг дэмжих системийн хэрэглэгчийн шаардлага тодорхойлох” ажлыг 2025 онд хийлгэн тайланг хүлээлгэн өгсөн.

Ингэснээр Цагдаагийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтсээс тус мэдээллийн санг тайлангийн дагуу шинэчлэн хийх ажлыг эхлүүлээд байна. Энэхүү системийг сайжруулснаар тус тасгийн үйл ажиллагааг хялбарчлан, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хилээр нэвтрэх хүүхдийн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, ХХГХ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэх, шаардлагатай тайлан, тоо мэдээллийг хялбар байдлаар нэгтгэн гаргах боломжтой болох юм.



IMPROVING DATABASE

The Anti-Trafficking Unit of the Organized Crime Division of the Criminal Police Department had been using an outdated database that did not fully cover the unit's operational needs. The system had limitations in recording complete information and could not be further upgraded.

To support the development of a new system, the project commissioned a User Requirements Assessment for a System to Support the Operations of the Anti-Trafficking Unit in 2025 and submitted the report to the National Police Agency.

Based on this report, the Information Technology Division of the National Police Agency has initiated the process of developing an upgraded database system.

Once improved, the system will help streamline the unit's operations by enabling faster processing of requests related to children crossing the border with authorized representatives, allowing more detailed recording of trafficking related information, and making it easier to compile necessary reports and statistical data.

ДАВАН ТУУЛАГЧДЫН СҮЛЖЭЭ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

Төслийн хүрээнд Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аар дамжуулан Даван туулагчдын сүлжээг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүллээ. “Даван туулагчдын сүлжээ” нь жендэрт суурилсан хүчирхийлэл, ХХГХ-ийн хохирогч охид эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэгтгэж, тэдний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх зорилготой сайн дурын бүлэг юм.

Тус сүлжээ нь даван туулагчдад сэтгэл зүй болон эдийн засгийн хувьд бэхжих орон зай бий болгох, бие биеэ дэмжих, туршлага хуваалцах хамт олон бүрдүүлэх, тэдний дуу хоолойг бодлогын түвшинд хүргэх, бие даан, тогтвортой үйл ажиллагаа зохион байгуулах чадвартай бүлгүүдийг бий болгох зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллуулдаг.

Хүйсийн тэгш эрхийн төв ТББ нь 2024 оны 2 сараас эхлэн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Даван туулагчдын сүлжээ байгуулах чиглэлээр ажилласан бөгөөд сүлжээний зорилгыг танилцуулан гишүүн элсүүлэх ганцаарчилсан уулзалтууд, идэвхжүүлэх бүлгийн уулзалтууд, нэгдсэн уулзалтууд, чадавхжуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан. Чадавхжуулах таван удаагийн сургалтад нийт 70 орчим даван туулагчийг хамруулсан.

Энэхүү сүлжээний үйл ажиллагаа тогтворжсоноор даван туулагчид ганцаардлыг даван туулж хурдан хугацаанд хэвийн амьдралдаа орох, харилцан дэмжлэг үзүүлэх, дуу хоолойгоо бодлогын түвшинд хүргэн, олон нийтийн ойлголт, хандлагыг эергээр өөрчлөх, оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх боломжтой болж байна.

ESTABLISHING A SURVIVORS' NETWORK

The project supported the establishment of a Survivors' Network through the Gender Equality Center NGO. The Survivors' Network is a voluntary group that brings together the voices of girls and women who have experienced gender-based violence and human trafficking, with the aim of protecting their rights and increasing their participation in advocacy and decision-making.

The network focuses on creating spaces where survivors can strengthen themselves psychologically and economically, support one another, and share experiences. It also aims to amplify survivors' voices at the policy level and to develop groups capable of organizing independent and sustainable activities.

Starting from February 2024, with financial support from the CPC project, the Gender Equality Center worked to establish the Survivors' Network. A series of activities were organized in phases, including individual outreach meetings to introduce the network and recruit members, group activation meetings, joint gatherings, and capacity-building trainings. Around 70 survivors participated in five capacity-building training sessions.

As the network continues to grow and strengthen, it provides survivors with opportunities to overcome isolation, rebuild their lives, support one another, and bring their voices to the policy level. It also contributes to raising public awareness, improving societal attitudes, and increasing participation and support for survivors.


ХОХИРОГЧИД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ САЙН ДУРЫН АЖИЛТАН БЭЛТГЭХ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд Хүйсийн тэгш эрхийн төв 2024 оны 2 сараас эхлэн хохирогчид туслалцаа үзүүлэх сайн дурын ажилтан бэлтгэж эхэлсэн.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд хуулийн байгууллагад хандах гэж буй хохирогч/үйлчлүүлэгч/даван туулагчдад зориулсан Та үүнийг мэдэх үү гарын авлагыг боловсруулж, хэвлүүлсэн. Тус гарын авлагын гол онцлог нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч/үйлчлүүлэгч/даван туулагчдын мэдвэл зохих хууль ёсны эрх, үүрэг, хуулийн байгууллагад хандсан тохиолдолд анхаарах асуудлын талаарх мэдээллийг багтаасан ба түүнчлэн сэтгэл зүйн зөвлөгөө санамжийг хамтад боловсруулснаар онцлог юм.

Сайн дурын ажилтнуудыг бэлтгэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж, сайн дурын үйл ажиллагааны онцлог, ач холбогдол, ХХГХ-ийн талаар ойлголт, тус гэмт хэргийн хохирогчдын онцлог, сэтгэцийн гэмтэл, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ үзүүлэх зэрэг олон талын мэдлэг олгосон. Эдгээр сургалтуудад МУБИС, Отгонтэнгэр, Их засаг зэрэг их сургуулийн 100 гаруй оюутан оролцсон байна.

Бэлтгэгдсэн сайн дурын ажилтнууд хохирогч/үйлчлүүлэгчийг мэдүүлэг өгөх үед өмгөөлөгчтэй хамтран уулзах, сэтгэл зүйг нь бэлтгэх, тогтвортой байлгах зэрэг мэргэжлийн туслалцаа үзүүлэх болон нотлох баримт бүрдүүлэх, байгууллагаас нотлох баримт гаргуулан авах зэрэг ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж байна.



PREPARATION OF VICTIM ADVOCATES



As part of the project activities, the Gender Equality Center NGO began preparing victim advocates in February 2024 to support victims of trafficking and gender-based violence.

Within this initiative, a guide titled “Did You Know?” was developed and printed for victims/clients/ and survivors who seek assistance from legal and law enforcement institutions. The guide provides information on the legal rights and responsibilities that victims should be aware of during criminal proceedings, as well as key issues to consider when approaching legal authorities. It also includes basic psychological guidance and supportive advice to help victims better prepare for the process.

Regular training sessions were organized to prepare victim advocates. These trainings covered topics such as the role and importance of victim advocacy, an overview of trafficking in persons, the characteristics and needs of victims, psychological trauma, and trauma-informed approaches to providing support. More than 100 students from universities including the Mongolian National University of Education, Otgontenger University, and Ikh Zasag International University participated in these trainings.



The trained victim advocates now support victims/clients/survivors by assisting them during meetings with attorneys before giving statements, helping them prepare psychologically and remain emotionally stable throughout the process. They also assist with practical tasks such as collecting evidence and facilitating the retrieval of documents from relevant institutions.

ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Төслийн зүгээс Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академитай хамтран энэхүү судалгааг 2024 онд хийсэн. Судалгаагаар хүн худалдаалах гэмт хэргийн ухагдахууныг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан агуулгыг тодруулах, мөн манай улсад хуульчилж ирсэн уламжлал, шүүхээр шийдвэрлэж буй практикийг судлахаас гадна гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж уг гэмт хэргийг хуульчлах, өрсөлдөх хэм хэмжээнээс ялган зүйлчлэх, ялын бодлогын хүрээнд санал дэвшүүлэхийг зорьсон.

Судалгааны үр дүнд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинж, ялын


бодлогыг өөрчлөх шаардлагатай гэж дүгнэсэн бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Албадан бэлгийн харьцаанд оруулах” хэмээн томъёолж өөр зүйлд хуульчлах, 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг буюу биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор үйлдсэн гэмт хэргийг 13.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хүндрүүлэх шинжид оногдуулах эрүүгийн хариуцлагыг хүн худалдаалах гэмт хэргээс хүнд ял оногдуулахаар хуульчлах, Улсын дээд шүүхээс хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарах бусад гэмт хэргийг ялган зүйлчлэх талаарх албан ёсны тайлбар гаргах зэрэг зөвлөмжийг өгсөн.

Судалгааны зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал боловсруулан Хууль, зүй, дотоод хэргийн яамд хүргүүлсэн бөгөөд мөн Шүүхийн академиас эрхлэн гаргадаг Монголын шүүх, эрх зүй судлал сэтгүүлд өгүүлэл болгон нийтлүүлж шүүгчдийн хүртээл болгосон.

АЛБАДАН ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН МӨЛЖЛӨГИЙН ЗОРИЛГООР ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран 2022 онд хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж, тухайн үеийн хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон судалгааны тайланг гаргасан.

Судалгааг хийхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн хавтаст хэргүүдийг судлан, дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ хохирогчийг тогтоох үндэслэл, зүйлчлэл өөрчлөгдсөн эсэх, хэрэг бүртгэгдсэнээс шийдвэрлэгдэх хүртэл зарцуулсан хугацаа, ажилтны тоо, ажлын ачаалал зэргийг нарийвчлан судалсан, хуулийн байгууллагад хандсан, хохирогчоор тогтоогдсон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн туслалцаа дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдалд 20 хохирогчоос авсан ярилцлагын үндсэн дээр дүн шинжилгээ хийснээрээ онцлог болсон.




Судалгааны үр дүнд эрх зүйн зохицуулалтын чиглэлээр, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр нийт 18 үр дүнг тодорхойлон тус бүрд тохирох зөвлөмжийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Судалгаагаар гарсан зөвлөмжийг СДХБ-ийн хуралдаан болон “Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: асуудал, шийдэл” хэлэлцүүлгийн үеэр танилцуулан хэлэлцүүлсэн. Судалгааны зөвлөмжийн дагуу хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн бөгөөд улмаар хуульд заасан журмуудыг шинээр болон шинэчлэн батлуулах ажил хийгдсэн юм.

RESEARCH REPORT ON THE ADJUDICATION OF TRAFFICKING IN PERSONS FOR THE PURPOSE OF FORCED LABOR AND LABOR EXPLOITATION

This study, conducted in 2025, examined the situation in Mongolia regarding the detection, investigation, oversight, and adjudication of crimes related to forced labor and trafficking in persons for the purpose of labor exploitation. The research aimed to identify the legal and practical challenges faced in addressing these crimes and to propose possible solutions and recommendations.

The study included a comparative analysis of international legal standards and domestic legislation, as well as an examination of the current practices in criminal proceedings related to these crimes. A notable feature of the research was the analysis of complaints received by labor inspectors and wage-related disputes resolved by civil courts, which provided additional insights into possible indicators of forced labor and labor exploitation.



One of the key findings revealed that 37.2% of the complaints handled by state labor inspectors involved situations resembling the indicators of forced labor identified by the International Labour Organization, such as child labor, forced labor, the use of coercion within employment relationships, discrimination, and exposure to harassment or violence. However, these cases had not been referred to law enforcement authorities for further investigation.

The project has disseminated the research findings to the public and continues to work with relevant institutions to support the implementation of the study's recommendations.


ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран 2022 онд хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж, тухайн үеийн хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон судалгааны тайланг гаргасан.

Судалгааг хийхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн хавтаст хэргүүдийг судлан, дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ хохирогчийг тогтоох үндэслэл, зүйлчлэл өөрчлөгдсөн эсэх, хэрэг бүртгэгдсэнээс шийдвэрлэгдэх хүртэл зарцуулсан хугацаа, ажилтны тоо, ажлын ачаалал зэргийг нарийвчлан судалсан, хуулийн байгууллагад хандсан, хохирогчоор тогтоогдсон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн туслалцаа дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдалд 20 хохирогчоос авсан ярилцлагын үндсэн дээр дүн шинжилгээ хийснээрээ онцлог болсон.

Судалгааны үр дүнд эрх зүйн зохицуулалтын чиглэлээр, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр, мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр нийт 18 үр дүнг тодорхойлон тус бүрд тохирох зөвлөмжийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Судалгаагаар гарсан зөвлөмжийг СДХБ-ийн хуралдаан болон “Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: асуудал, шийдэл” хэлэлцүүлгийн үеэр танилцуулан хэлэлцүүлсэн. Судалгааны зөвлөмжийн дагуу хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн бөгөөд улмаар хуульд заасан журмуудыг шинээр болон шинэчлэн батлуулах ажил хийгдсэн юм.




ANALYSIS ON LEGAL PROCEEDINGS OF TRAFFICKING IN PERSONS AND SIMILAR CASES

In 2022, the project collaborated with the Gender Equality Center NGO to conduct an Analysis On Legal Proceedings of Trafficking in Persons and Similar Crimes. The study aimed to better understand the situation of trafficking in persons cases and how they were handled within the criminal justice system.

The research examined case files of trafficking in persons and similar crimes resolved during the previous three years. The analysis focused on several aspects, including the criteria used to identify victims, changes in legal classification of cases, the time required for cases to proceed from registration to resolution, and the number of personnel involved and their workload. In addition, the study included interviews with 20 victims of trafficking in persons who had sought assistance from legal institutions and had been formally identified as victims. These interviews provided insights into the current support and services available to victims.

As a result of the study, 18 key findings were identified across several areas, including legal regulation, administrative investigation procedures, criminal investigation practices, and court proceedings. Based on these findings, recommendations were developed and submitted to the relevant institutions.

The recommendations were also presented and discussed during the MDTF meetings and at the annual Prosecution Workshop discussions. Following these recommendations, an impact assessment of the implementation of the Law on Combating Trafficking in Persons was conducted, which later supported the development and revision of several procedures under the law.




ХОХИРОГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Хохирогч иргэдийн мэдээллийн сан буюу ХИМС систем нь Монгол Улсад хохирогчийн мэдээллийг тогтоосон журам, нууцлалын шаардлагын дагуу бүртгэн ажилладаг мэдээллийн сан юм.

Одоогоор энэхүү системд 44 байгууллагын 75 хэрэглэгч буюу хохирогч хамгааллын үйлчилгээний байгууллага албан тушаалтнуудаар дамжин нийт 4000 гаруй хохирогчийн кейсийг давхардсан тоогоор бүртгэн үйлчилгээ үзүүлж байна.


ХИМС систем нь шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай зөв зохистой байдлаар нь хүргэх, холбон зуучлахаас гадна судалгаа, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой бөгөөд хохирогчийн мэдээллийг аюулгүй хадгалах нууцлалыг хангасан.



44
БАЙГУУЛЛАГА



75
ХЭРЭГЛЭГЧ



CHILD VICTIM REGISTRATION SYSTEM

The Child victim registration system is a national information system in Mongolia that registers victim-related information in accordance with established procedures and confidentiality requirements.

Currently, the system records and provides services for more than 4,000 victim cases (including duplicates) through 75 users from 44 organizations, all of which are service providers and officials working in victim protection.

The Child victim registration system is designed to ensure that victims receive the necessary assistance and services promptly, efficiently, and appropriately, and to facilitate referrals when needed. It also plays an important role in research and the development of prevention policies, while ensuring the secure storage and confidentiality of victim information.

ГЭРЭЭР АЙЛЧЛАГЧ ХӨТӨЛБӨР

2021 оноос 2024 оны хооронд Гэрээр айлчлагч хөтөлбөрийг СХД, БГД, ЧД, СБД, БЗД тус бүрд ЗДТГ-н Нийгмийн хөгжлийн хэлтсээр ахлуулсан ажлын хэсэг байгуулан Скаутын холбоо, Монголын Сайн Дурынхны Төв, Лантуун Дохио, Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв, Боловсрол Ирээдүй Хөгжлийн Гарц зэрэг 5 төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. Хэрэгжүүлэгч байгууллагуудын чадваржуулах сургалтууд тогтмол хийгдэж нийт 220 гэрээр айлчлагч нараар дамжуулан 1000 өрхийг сонгон тогтмол айлчлал хийж үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж дуусгасан.



Өсвөр үеийнхний хөгжлийн төв



Монголын скаутын холбоо



Монголын сайн дурынхны төв



Лантуун дохио ТББ



Боловсрол ирээдүй хөгжлийн гарц ТББ

Гэрээр айлчлагчид нийт 1219 тохиолдлыг цааш ‘хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, бичиг баримтжуулах, ажилд зуучлах, хууль эрх зүйн тусламж, сэтгэл зүйч, нэн шаардлагатай хандив тусламж’ зэрэг төрийн болон бусад үйлчилгээнд холбон зуучилж ажилласан байна.

HOME VISITOR

From 2021 to 2024, the Home Visitor Program was implemented in Songinokhairkhan, Bayangol, Chingeltei, Sukhbaatar, and Bayanzurkh districts. In each district, a working group chaired by the Social Development Division of the Governor’s Office was established, and the program was carried out in partnership with five NGOs: the Scout Association, the Center for Mongolian Volunteers, Lantuun Dohio, the Youth Development Center, and the Education-Future-Development Gateway.

The implementing organizations received regular capacity building trainings, and through a total of 220 home visitors, the program successfully selected and conducted regular visits to 1,000 households, completing the planned activities.

Home visitors referred a total of 1,219 cases to relevant government and non government services, including child protection, education, health, civil registration, employment services, legal aid, psychological support, and essential emergency assistance.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ, СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ НЭВТРҮҮЛЭХ

Дотоод хэргийн их сургуулийн багш нарт ХХГХ-ийн хохирогчтой хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй, сэтгэцийн гэмтэлд суурилсан арга барилаар ажиллах арга зүй эзэмшүүлэх сургалтыг 2026 оны 1 сарын 5-9 өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн 16, Хилийн албаны сургуулийн 5, Ахлагч мэргэжлийн боловсролын сургуулийн 5 багш оролцсон. Энэхүү сургалтаар ХХГХ-ийн ойлголт, хохирогчийг олж илрүүлэх, сэтгэцийн гэмтлийн талаар ойлголт, ярилцлага хийх форензик ярилцлагын аргачлал зэрэг өргөн хүрээний сэдвийг дотоод болон гадаадын сургагч багш нараар дамжуулан хүргэсэн. Сургалтын сүүлийн өдөр багш нар өөрсдийн заадаг хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийн, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах санал гарган танилцуулсан бөгөөд төслийн зүгээс хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах ажилд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн багш нарыг дээрх агуулгын дагуу сурган, хөтөлбөрт шинэтгэл хийснээр ирээдүйн хууль сахиулах байгууллагын алба хаагч нарт хохирогчтой ажиллах зөв хандлагыг сургуульд суралцах явцад нь төлөвшүүлэх боломжтой болж байгаа юм. Ингэснээр ХХГХ-ийн хохирогчийг таньж илрүүлэх байдал нэмэгдэх, хохирогчийг дахин хохироох эрсдэл буурах боломжтой.



INTEGRATING VICTIM-CENTERED, CHILD-FRIENDLY, AND TRAUMA-INFORMED APPROACHES INTO THE ACADEMIC CURRICULUM OF THE UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS



A training was organized for faculty members of the University of Internal Affairs from January 5–9, 2026, aimed at strengthening their knowledge of the victim-centered, child-friendly, and trauma-informed approaches to working with victims of trafficking.

The training was attended by 26 instructors, including 16 from the Police School, five from the Border Protection School, and five from the School of Non-Commissioned Officers. Through sessions delivered by both national and international trainers, participants were introduced to a wide range of topics, including the concept of trafficking in persons, victim identification, understanding psychological trauma, and the use of forensic interviewing techniques.

On the final day of the training, participants reviewed the courses they currently teach and presented recommendations for improving and updating the curriculum. The project is continuing to support efforts to integrate these approaches into the university's training programs.



By strengthening the capacity of instructors and updating the curriculum, future law enforcement officers will be better equipped with the knowledge, skills, and attitudes needed to work effectively with victims. This will contribute to improved identification of trafficking victims and help reduce the risk of re-victimization during the response process.



ХҮҮХДИЙН ЭРХИЙН БАЙЦААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдлыг 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулиар өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд, улмаар хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг боловсруулах, орон тоог тогтоох аргачлалыг боловсруулахад ГБХНХЯ-д дэмжлэг үзүүлэн ажиллав.



ГБХНХЯ, ХГБХХЕГ болон ОУХБ-тай хамтран Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй нийт хөдөлмөрийн хяналтын болон хүүхдийн эрхийн улсын байцаагчдад хяналт шалгалт хийх үедээ хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийг таньж илрүүлэх агуулгаар сургалт зохион байгуулсан ба хүүхдийн эрхийн байцаагчдын давтан сургалтыг зохион байгуулахад ГБХНХЯ-д дэмжлэг үзүүлэн ажилласан.

2025 оны 9-р сард Хүүхдийн эрхийн байцаагчдын туршлага судлах аяллыг АНУ-д зохион байгуулж, ГБХНХЯ, ХГБХХЕГ болон орон нутгийн нийт 9 байцаагчийг хамруулсан нь тэдэнд АНУ-ын хүүхэд хамгааллын тогтолцоо, хүүхдийн эсрэг зөрчлийг илрүүлэх, тогтоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны бодит туршлага, үр дүнтэй аргачлалуудыг гүнзгийрүүлэн ойлгох боломж бүрдүүлж, Монгол дахь хяналт шалгалт, хариу үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн шинэ мэдлэг, санаачилгыг бий болгоход хувь нэмэр орууллаа.

CAPACITY BUILDING FOR STATE CHILD RIGHTS INSPECTORS

The 2024 Law on Child Protection provided a comprehensive legal definition of the mandate of State Child Rights Inspectors. Accordingly, the project supported the MFLSP in developing the standard operating procedures for State Child Rights Inspectors and methodology for determining inspector quotas at the local level.

In collaboration with the MFLSP, the GACFDP, and the International Labour Organization, the project organized trainings for all labor inspectors and child rights inspectors nationwide on identifying children who may be victims of labor exploitation or sexual exploitation during routine inspections. The project also supported the MFLSP in delivering refresher trainings for State Child Rights Inspectors.



In September 2025, the project organized a study tour to the United States for nine inspectors from the MFLSP, GACFDP, and local government. This experience enabled participants to gain a deeper understanding of the U.S. child protection system and practical approaches to identifying, assessing, and responding to child protection violations. The exposure contributed to strengthening the quality of inspection and response services in Mongolia by equipping inspectors with new knowledge and ideas for improving practice.



АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ

Аж ахуйн нэгж бизнесийн үйл ажиллагаанд хүүхдийн эрхийг ханган хамгаалах хандлагыг бэхжүүлэх нь хүүхэд аливаа хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалагдах нэг чухал нөхцөл болдог. НҮБ-ийн Хүүхдийн сангийн “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим”-ыг аж ахуй нэгж байгууллагуудад түгээх зорилгоор ГБХНХЯ, НҮБ Хүүхдийн сантай хамтран 2022 оны 12-р сарын 12-15-нд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэл бусад төрийн ба төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн нийт 110 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн. 2023 оны 4, 5-р саруудад дээрх сургагч багш нар Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Булган, Эрдэнэт, Говьсүмбэр аймаг болон Багахангай дүүрэгт Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим сэдэвт сургалтыг орон нутгийн байгууллага аж ахуйн нэгжийн менежерүүдэд зохион байгуулснаар нийт 600 орчим албан хаагчид үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг ханган хамгаалах талаар арга зүйн мэдлэгтэй болсон.



Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т заасны дагуу аж ахуйн нэгж байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлоготой байх, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.7 дахь хэсэгт заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогод заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулж аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн нийт цалингийн сангийн 1 хувийг зарцуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Монгол



дахь Америкийн худалдааны танхимын гишүүн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үр дүнд аж ахуйн нэгжүүд хүүхэд хамгааллын асуудлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнд татварын зохих хөнгөлтөлт эдлэх боломжийн талаар мэдлэгээ нэмэгдүүлэв.



PROMOTING CHILD RIGHTS IN BUSINESS ACTIVITIES

Strengthening a child rights within business operations is an important condition for ensuring that children are safeguarded from any form of violence and exploitation. Through promoting UNICEF's Children's Rights and Business Principles among companies, the project in collaborations with MFLSP and UNICEF, jointly trained 110 specialists from the Mongolian National Chamber of Commerce and Industry, the Confederation of Employers, the Confederation of Trade Unions, and other governmental and non-governmental organizations as trainers during 12–15 December 2022.

In April and May 2023, these trainers conducted trainings on the Children's Rights and Business Principles for managers of local government agencies and businesses in Khentii, Dornod, Sukhbaatar, Bulgan, Orkhon, Govisumber aimag, and Bagakhangai district. As a result, around 600 officials gained methodological knowledge on how to integrate and uphold children's rights within their operations.

In accordance with Article 43.3 of the Labor Law, every business entity is required to have a child protection policy. In line with Article 52.7 of the Law on Child Protection, businesses must also allocate 1 percent of their total wage fund to implement the activities specified in their child protection policy. To support the implementation of these legal requirements, a discussion was organized among member companies of the American Chamber of Commerce in Mongolia. As a result of the discussion, businesses enhanced their understanding of how they can prevent child protection risks and benefit from relevant tax incentives for activities carried out as part of their social responsibility efforts.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨН

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан 2023, 2024, 2025 онуудад ГБХНХЯ болон ОУХБ-тай хамтран Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Бодлогын зөвлөгөөнийг жил бүрийн 6 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулав. Эдгээр зөвлөгөөнд Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам болон түүний харьяа байгууллагууд, Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн үндэсний комисс, салбар яамд, нийслэл болон орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсүүд, хөдөлмөрийн гурван талт түншлэл, ОУХБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, ЕХ-ны Төлөөлөгчийн газар, АНУ-ын ЭСЯ, Дэлхийн Зөн Монгол, Азийн Сан зэрэг олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, их дээд сургуулиудын төлөөлөл өргөнөөр оролцов. Зөвлөгөөнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар ажилладаг мэргэжилтнүүд, төрийн албан хаагчид, үйлчилгээний тэргүүн шугамд ажилладаг ажилтнууд, хүүхдийн эрх болон хөдөлмөрийн улсын байцаагчид, хүүхдийн төлөөлөл, хүүхэд хамгаалал болон хөдөлмөрийн хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр хамтран ажилладаг түнш байгууллагуудаас багтсан 100 гаруй оролцогчид жил бүр оролцож үндэсний хэмжээнд тулгамдаж буй тухайн асуудлаар нээлттэй саналаа солилцсон.

2023 онд зохион байгуулагдсан зөвлөгөөн нь тогтвортой хөгжлийн зорилтын (8.7) хүрээнд Монгол Улс дахь хэрэгжилтийг үнэлэх, ҮСХ-ны хүүхдийн хөдөлмөрийн судалгааны үр дүнг хэлэлцэх, Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг сайжруулах асуудлыг хөндөж, салбар хоорондын бодлогын санал, зөвлөмжүүдийг гаргасан. 2024 онд зохион байгуулсан зөвлөгөөн нь хүүхдийн хөдөлмөрийг устгах олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэж, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, албадан хөдөлмөр, олон улсын хөдөлмөрийн бодлого стандарт, Хүүхэд хамгааллын компакт түншлэлийн хэрэгжилт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар хэлэлцсэн. 2025 онд хүүхдийн хөдөлмөрийн хяналтын тогтолцоог сайжруулахад гол анхаарлаа хандуулж, хөдөлмөрийн хяналт шалгалт, Эрүүгийн хуулийн холбогдох заалтын (16.10 зэрэг) хэрэгжилт, хил нэвтрэхэд тавих хяналт, боловсрол, соёл, спорт, аялал жуулчлал, нийгмийн хамгааллын салбар дахь таньж илрүүлэх ба холбон зуучлах үйл явцын талаар нарийвчилсан хэлэлцүүлэг өрнүүлсэн. Эдгээр зөвлөгөөний үр дүнд бодлогын залгамж зөвлөмжүүд боловсруулагдаж, байгууллагуудын уялдаа холбоо бэхжиж, хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний хүчин чармайлтыг шат дараатай ахиулах нийтлэг ойлголт, хамтын ажиллагаа бий болов.



NATIONAL FORUMS ON CHILD LABOR

Over three consecutive years, 2023, 2024, and 2025, National forums were held on June 12, aligning with the International Day Against Child Labour. The forums brought together a wide range of stakeholders, including the Ministry of Family, Labor and Social Protection (and its departments), the National Statistical Office, the National Human Rights Commission, sectoral ministries, local Family and Children Departments, tripartite labor partners, international organizations such as the ILO, UNICEF, the EU Delegation, the U.S. Embassy, civil society organizations, academia, and representatives from WV and TAF. Attendance at each forum exceeded 100 participants and included technical experts, government officials, frontline service providers, Child rights and labor inspectorates, child representatives, and partner organizations dedicated to improving child protection and labor monitoring systems in Mongolia.



Across the three years, each forum addressed evolving national priorities on child labor. The 2023 forum focused on reviewing Mongolia's progress toward SDG 8.7, discussing findings from the National Statistical Office's child labor survey, and strengthening implementation of the revised Labor Law, resulting in a set of inter sectoral policy recommendations. The 2024 forum emphasized multisector cooperation to eliminate child labor, including discussions on hazardous labor, forced labor, international standards, and updates on the CPC project, which led to strengthened collaboration and renewed policy actions. The 2025 forum concentrated on improving the national child labor monitoring system, with detailed technical sessions on labor inspection, Criminal Code (for instance 16.10) enforcement, border control mechanisms, and identification and referral processes across education, culture, sports, tourism, and social protection sectors. Together, the three forums generated a continuum of policy recommendations, reinforced cross agency coordination, and built shared understanding among national actors, contributing to progressive improvements in Mongolia's child labor prevention and response efforts.

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ

Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Ухаалаг хөтөч”, “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой”, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” гэсэн хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан 3 төрлийн хөтөлбөрийг Анбаунд Монгол ТББ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд агуулгыг боловсруулан гаргаж 2022 оны 10-р сараас 2024 оны 5-р сар дуустал хугацаанд нийслэлийн зорилтот таван дүүрэгт нийт 64 сургууль, МСҮТ дээр 100 гаруй Өсвөрийн Клубуудээр дамжуулан хэрэгжүүлж нийт 2800 гаруй сурагчдад хүрсэн.



“Ухаалаг хөтөч” хөтөлбөр нь нийт 31 хичээлээс бүрдэх ба өсвөр үеийнхнийг өөрсдийгөө болон үе тэнгийнхээ хүүхдүүдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдний тус гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөтөлбөр юм. Харин “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой” (ӨТДХ) хөтөлбөр нь

хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийг бууруулах нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулах арга зүйг алхам алхамаар дэлгэрэнгүй зааварчилсан хөтөлбөр. Энэ хөтөлбөрийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар нөлөөллийн ажил хийх сонирхолтой 14-өөс дээш насны өсвөр үеийхэнтэй ажиллах чиглүүлэгч багшид зориулан боловсруулсан. Энэхүү клубт сурагчид өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, бусдыг сонсох, хамтран ажиллах, нийгмийн эерэг өөрчлөлтөд хувь нэмэр оруулах чадварыг илүүтэйгээр хөгжүүлдэг.

“Ухаалаг Хөтөч, Өөрчлөлтийн Төлөөх Дуу Хоолой” өсвөрийн клубт хамрагдсанаар сурагчид шийдвэр гаргах, үр дүнтэй харилцах, хувийн зохион байгуулалт, амьдрал төлөвлөх, эрсдэлээс сэргийлэх, аюулаас зайлсхийх, хүн худалдаалах гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, чадварыг олж авсан. Мөн эдгээр хөтөлбөрүүдэд хамрагдсан сурагчид



хөтөлбөрийн гарын авлагын дагуу хүний наймаа, аюулгүй шилжилт хөдөлгөөн, цахим орчин дахь бэлгийн мөлжлөгийн талаарх нөлөөллийн аяныг санаачлан төлөвлөж, хэрэгжүүлсэн. Нийт 29 клуб өөрийн сургуулиудад болон сургуулийн ойр олон нийтэд нөлөөллийн аяныг үйл ажиллагаануудаар дамжуулан биечлэн болон цахимаар нийт 45 мянга гаруй хүнд ХХГХ-ийн талаар мэдээлэл түгээсэн.

“Цахим Орчин дахь Хүүхдийн Аюулгүй Байдал хөтөлбөр” нь 10-14 насны хүүхдүүдэд зориулагдсан. Энэ хөтөлбөрт багшийн гарын авлага, танилцуулга, хүүхдийн комик ном, эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан гарын авлага багтана. Хөтөлбөрт хамрагдсанаар сурагчид цахим орчныг хариуцлагатай ашиглах, хувийн мэдээллээ хамгаалах, технологийн талаарх суурь ойлголттой болж цахим орчинд үүсч болзошгүй аюулыг таних, урьдчилан сэргийлэх мэдлэг, ур чадварыг эзэмшиж, хүн худалдаалах зэрэг эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварыг эзэмшээд байна.



2025 оноос Төрийн Цахим Үйлчилгээний Зохицуулалтын Газар Хамтын ажиллагааны хүрээнд ЦОХАБ хөтөлбөрийг улс даяар үйл ажиллагаа явуулдаг “ХУРДАН” клубийн гишүүдээр дамжуулан хэрэгжүүлж эхлээд байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон Боловсролын ерөнхий газартай хамтран “Цахим орчны хүүхдийн аюулгүй байдал” хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр түгээх чиглэлээр байгууллага хооронд хамтын

ажиллагааг бэхжүүлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж хамтран ажиллах үр дүнтэй алхмуудыг хэлэлцсэн.

Дээрх хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх үүднээс хөтөлбөрийн арга зүйн дагуу нийт 300 орчим багш нарыг клубын чиглүүлэгч багшаар бэлтгэн төслийн хугацаанд давтан сургалтыг тус бүр нэг удаа зохион байгуулж багш нарын туршлага солилцохуулзалтуудыг тус бүр 2 удаа зохион байгуулснаар багш нар амжилттай хэрэгжүүлсэн туршлагаа хуваалцан, сорилт бэрхшээлээ даван туулах арга чадваруудаа дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

CHILD AND YOUTH EMPOWERMENT

Three Child and Youth (CAY) club toolkits—“Smart Navigator,” “Voice up for Change,” and “Keeping children safe online”—were jointly developed and implemented through the collaboration of Unbound Mongolia NGO, the National Institute for Educational Studies, and the Communications Regulatory Commission. From October 2022 to May 2024, the programs were delivered in 64 schools and TVET centers across five target districts of Ulaanbaatar, reaching over 2,800 students through more than 100 CAY Clubs.

The “Smart Navigator” program consists of 31 lessons designed to help children protect themselves and their peers from trafficking and reduce their vulnerability to such crimes. Meanwhile, the “Voice up for Change” (VUFC) program provides step-by-step guidance for conducting effective awareness-raising activities to reduce the risks of trafficking in persons. This program is intended for children aged 14 and above who are interested in implementing anti-trafficking advocacy initiatives. Through this club, students strengthen their abilities to express their views, listen to others, collaborate, and contribute to positive social change.




By participating in the Smart Navigator and Voice up for Change CAY clubs, students gained knowledge and skills in decision-making, effective communication, self-management, life planning, risk reduction, and protection from danger—including safeguarding themselves and others from trafficking in persons. Students who completed these programs independently initiated and implemented awareness campaigns on trafficking in persons, safe migration, and online sexual exploitation, based on the toolkits. A total of 29 clubs organized



advocacy campaigns within their schools and nearby communities, reaching more than 45,000 people both in-person and online with information about combating trafficking in persons.

The “Smart Navigator” program consists of 31 lessons designed to help children protect themselves and their peers from trafficking and reduce their vulnerability to such crimes. Meanwhile, the “Voice up for Change” (VUFC) program provides step-by-step guidance for conducting effective awareness-raising activities to reduce the risks of trafficking in persons. This program is intended for children aged 14 and above who are interested in implementing anti-trafficking advocacy initiatives. Through this club, students strengthen their abilities to express their views, listen to others, collaborate, and contribute to positive social change.

The “Keeping children safe online” program targets children aged 10–14. The program includes a facilitator’s guide, presentations, a children’s comic book, and a booklet for parents and caregivers. Through the program, students learn responsible online behavior, personal data protection, basic digital literacy, and how to identify and prevent potential online risks. They also acquire skills to protect themselves and others from risks such as trafficking in persons.



Beginning in 2025, the Government Digital Services Regulatory Authority, as part of its partnership efforts, has started implementing the Keeping Children Safe Online toolkits nationwide through members of the “KHURDAN” clubs. Additionally, the Authority and the General Agency for Education are collaborating to strengthen inter-agency cooperation to sustain the program, expand local-level training, and effectively disseminate awareness and educational activities on child safety in the digital environment.

To ensure successful implementation of the above programs, over 300 teachers were trained as CAY club facilitators following the methodological framework of the programs. During the project period, refresher trainings were organized once for each group of facilitators, and two rounds of experience-sharing meetings were held. These activities enabled facilitators to exchange successful practices, overcome challenges, and enhance their capacity to effectively implement the CAY club toolkits.

ХАКАТОН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хүүхэд, залуучуудын анхаарлыг хандуулах, оролцоог нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой. Тэр дундаа урьдчилан сэргийлэх ажилд залуучуудаас гарсан санал, санаачилгыг ашигласнаар тэдэнд илүү хүрэх боломжтой байдаг. Тиймээс хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинэлэг санал, санаачилгыг хэрэгжүүлэх, хүүхэд, залуучуудын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлд тэдний анхаарлыг хандуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн чиглэлээр их сургуулиудад суралцдаг оюутнуудын дундах хакатон тэмцээнийг 2025 оны 10 сард зохион байгуулсан.



Хакатон уралдаанд 5 их сургуулийн 34 багийн 155 оюутан бүртгүүлснээс II шатанд 5 сургуулийн 10 багийн 45 оюутныг шалгаруулан “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд өөрсдийн гаргасан шилдэг санаа, шийдлээ уралдуулсан. Багууд VR технологи хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, яаралтай тусламж авах аппликейшн хөгжүүлэх, чатбот ажиллуулах, шуурхай мэдээллийн цахим сан үүсгэх зэрэг шинэлэг саналуудыг гаргасан.

Энэхүү уралдааны үр дүнд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг санаачилгуудыг гарган авснаас гадна ирээдүйн хуулийн мэргэжилтнүүдэд хүн худалдаалах гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, тэднийг энэ сэдвээр илүү дэлгэрүүлж судлахад чиглүүлсэн арга хэмжээ болсноороо онцлог юм.



HACKATHON COMPETITION

Engaging children and young people in efforts to prevent trafficking in persons is essential. In particular, initiatives and ideas generated by youth themselves can be highly effective in reaching their peers and raising awareness.

With this in mind, the project organized a hackathon competition in October 2025 among university students studying law, aiming to encourage innovative ideas for preventing trafficking in persons, increase students' knowledge of the issue, and promote youth engagement in prevention efforts.



A total of 155 students from 34 teams representing five universities registered for the competition. Ten teams with 45 students from the five universities were selected for the second round to present and compete with their best ideas and solutions under the theme “Preventing Trafficking in Persons.”

The participating teams proposed a range of innovative solutions, including the development of VR-based awareness tools, mobile applications for prevention and emergency assistance, chat-bots, and an online rapid information database.

The competition not only generated innovative ideas for preventing trafficking in persons, but also provided future legal professionals with deeper knowledge of the issue and encouraged them to conduct further research and engagement on this important topic.



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЯН

Төслөөс хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд залуучуудыг өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2 удаагийн соён гэгээрүүлэх кмапанит ажлыг 2023-2025 онуудад зохион байгуулсан.

“МЭДДЭГ МЭДЭЭЛДЭГ БАЙЯ” аян 2023 онд



Агуулга:

Хүн худалдаалах гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, цахим аюулгүй орчин, энэ гэмт хэргийг эрсдэл урьдчилан сэргийлэх мэдээллүүдийг олон нийтэд түгээв.


Үр дүн:

- Хөдөлмөрийн мөлжлөгийн талаарх ойлголт 11-ээс 48 хувь хүртэл,
- Бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт мэдлэг 20-оос 49 хувь хүртэл
- Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт мэдлэг 15-аас 46 хувь хүртэл өссөн үр дүн гарчээ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХҮҮХЭД ӨРТӨХӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

“МЭДДЭГ, МЭДЭЭЛДЭГ БАЙЯ” АЯН






“ХӨХ ЗҮРХНЫ АЯН” Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэлхийн өдөр

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас жил бүрийн 7 дугаар сарын 30-ны өдрийг “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх дэлхийн өдөр” болгон зарлаж, уг өдрийг тохиолдуулан “Хөх зүрх” аяныг дэлхий даяар өрнүүлдэг. Энэхүү аян нь хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хамтдаа тэмцэх, хохирогчдод туслалцаа дэмжлэг үзүүлэх, тэдний эрхийг хамгаалахад олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой бөгөөд улс орнууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийг нэгдэхийг уриалдаг.

Энэ хүрээнд Анбаунд Монгол ТББ, Дэлхийн Зөн Монгол, Азийн Сан байгууллагууд нь Хүүхэд хамгааллын түншлэлийн Компакт (CPC) төслийн хүрээнд “Хөх зүрх” аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж ирсэн билээ.





“BLUE HEART CAMPAIGN” World Day against Trafficking in Persons

The United Nations has designated July 30 of each year as the World Day against Trafficking in Persons and marks the occasion by launching the “Blue Heart” Campaign worldwide. The campaign aims to unite efforts to combat human trafficking, provide assistance and support to victims, and raise public awareness about the protection of their rights, calling on countries, government and non-government organizations, and individuals to take collective action.

In this context, Unbound Mongolia NGO, World Vision Mongolia, and The Asia Foundation have annually organized the “Blue Heart” Campaign under the framework of the Child Protection Compact (CPC) project, consistently implementing activities to prevent and protect children from trafficking in persons.

“МӨРӨӨДЛИЙНХӨӨ ЗҮГ” Аян




Агуулга:

- Аяны 1-р шат 2024 онд. Хүн худалдаалах гэмт хэрэг, ялангуяа бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх мэдээллүүд
- Аяны 2-р шат 2025 онд. Хүн худалдаалах гэмт хэрэг, ялангуяа хүүхэд хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон мэдээллүүд

Үр дүн:

- Иргэдийн 16% нь хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, 26% нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэддэг гэж тус тус хариулсан байна.
- “Хүүхдийн хөдөлмөр эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн нас”-г судалгаанд оролцогчдын дөнгөж 4% нь 15 нас гэж хариулсан бол 36% нь 16 нас, 50% нь 18 нас гэж хариулсан байна. Харин 15-с доош гэж 3%, 18-с дээш гэж 5% нь хариулсан.
- Хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн урьдчилан сэргийлэх, анхааруулсан мэдээ мэдээллийг авч байсан гэж насан хүрэгчдийн 78% нь хариулсан байна. Хүүхдийг албадан хөдөлмөрлүүлсэнтөхиолдолд тухайн хүнд “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой” гэж 83% нь хэлж байна.



Хүүхдийн эрхийг хамгаалах нь таны хайр

Та үүнийг мэдэж байх ёстой:

Өр төлөөсөөр хөдөлмөрлүүлэх нь хориотой.
Хүүхэд өр барагдуулах хэрэгсэл биш.

Хамжлагын албат болгох нь хууль бус
Хүүхэд айлын гэрийн үйлчлэгч, туслах малчин мэт ажиллах ёсгүй.

Албадан хөдөлмөрлүүлэх нь гэмт хэрэг
Айлгах, хүч хэрэглэх нь хүүхдийн ирээдүйг үгүй хийдэг.

Эцэг эх, асран хамгаалагч бидний хамгийн том үүрэг бол хүүхдэдээ **сурч боловсрох, тоглож наадах, мөрөөдлөө биелүүлэх** эрх чөлөөг нь хамгаалах юм.



“TOWARDS YOUR DREAM” Campaign

Content:

- Phase 1 (2024): Delivered information focused on preventing trafficking in persons, particularly sexual exploitation.
- Phase 2 (2025): Will focus on preventing children from being exposed to labor exploitation and sharing related information.



Results:

- 16% of respondents reported that they are aware of the worst forms of labor, while 26% stated that they are aware of trafficking in persons.
- Regarding the legally permitted minimum age for child labor, only 4% of survey participants answered 15 years old, while 36% answered 16 years old and 50% answered 18 years old. In addition, 3% responded under 15, and 5% responded over 18.
- 78% of adults reported that they had received preventive or warning information related to the worst forms of labor. 83% stated that criminal liability should be imposed on individuals who force children into labor.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД



ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР




БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДСЭНИЙ ХҮРЭЭЛЭН




ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ
ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО
MONGOLIAN EMPLOYERS FEDERATION

the 1990s, the number of people in the world who are under 15 years of age is expected to increase from 1.1 billion to 1.5 billion (United Nations 1994).

There are a number of reasons why the world's population is growing so rapidly. One of the main reasons is that the number of children born to each woman has increased. This is due to a number of factors, including the fact that women are now having children at a younger age, and that there is a higher birth rate in developing countries.

Another reason why the world's population is growing so rapidly is that the number of people who are surviving to old age has increased. This is due to a number of factors, including the fact that people are now living longer, and that there is a higher death rate in developing countries.

There are a number of reasons why the world's population is growing so rapidly. One of the main reasons is that the number of children born to each woman has increased. This is due to a number of factors, including the fact that women are now having children at a younger age, and that there is a higher birth rate in developing countries.

Another reason why the world's population is growing so rapidly is that the number of people who are surviving to old age has increased. This is due to a number of factors, including the fact that people are now living longer, and that there is a higher death rate in developing countries.

There are a number of reasons why the world's population is growing so rapidly. One of the main reasons is that the number of children born to each woman has increased. This is due to a number of factors, including the fact that women are now having children at a younger age, and that there is a higher birth rate in developing countries.

Another reason why the world's population is growing so rapidly is that the number of people who are surviving to old age has increased. This is due to a number of factors, including the fact that people are now living longer, and that there is a higher death rate in developing countries.

There are a number of reasons why the world's population is growing so rapidly. One of the main reasons is that the number of children born to each woman has increased. This is due to a number of factors, including the fact that women are now having children at a younger age, and that there is a higher birth rate in developing countries.

Another reason why the world's population is growing so rapidly is that the number of people who are surviving to old age has increased. This is due to a number of factors, including the fact that people are now living longer, and that there is a higher death rate in developing countries.